




# ДОТНЫ ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨРТӨГ, ЗАРДЛЫН ТООЦОО

УЛААНБААТАР  
2020 ОН



# ДОТНЫ ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨРТӨГ, ЗАРДЛЫН ТООЦОО

ЭЦСИЙН ТАЙЛАН  
2020 ОНЫ 5 ДУГААР САРЫН 12

Бэлтгэсэн:  
Мринал Чадха, Каролайн Форд, Ната Дувври  
Ирландын Үндэсний Их Сургууль



# АГУУЛГА

<b>Хураангуйлсан үгсийн жагсаалт.....</b>	<b>i</b>
<b>Талархал .....</b>	<b>ii</b>
<b>Хураангуй.....</b>	<b>iii</b>
<b>1. Танилцуулга.....</b>	<b>1</b>
1.1 Судалгааны бүтэц .....	2
1.2 Судалгааны тойм.....	2
1.3 Судалгааны зорилтууд .....	3
<b>2. Нөхцөл байдал .....</b>	<b>5</b>
2.1 Нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал .....	5
2.1.1 Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал .....	5
2.1.2 ОЭЭХ-ийн талаарх хууль, бодлого .....	5
2.2 Монгол улс дахь охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл .....	7
<b>3. Аргачлал .....</b>	<b>9</b>
3.1 Хувь хүн өөрөө гаргасан зардлууд .....	9
3.1.1 Эрүүл мэндийн зардлууд .....	9
3.1.2 Нийгмийн үйлчилгээ авах зардал .....	10
3.1.3 Гэрлэлт цуцлуулах зардал .....	11
3.2 Цалин хөлсгүйгээр ажилладаг өрхийн аж ахуй, асаргааны ажлууд .....	11
3.3 Алдагдсан орлого.....	12
3.4 Хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал.....	13
3.5 ЖСХ-ийг шийдвэрлэхэд шаардагдах хөрөнгө, эх үүсвэр.....	14
3.6 ДХХ-ээс үүдсэн нийт зардал/хохирол .....	15
<b>4. Үр дүн .....</b>	<b>16</b>
4.1 Сүүлийн 12 сард хувь хүн өөрөө гаргасан зардлууд .....	16
4.1.1 Эрүүл мэндийн зардлууд .....	16
4.1.2 Нийгмийн үйлчилгээний зардлууд .....	17
4.1.3 Гэр бүл салалтын зардал.....	17
4.2 Төлбөр төлөгдөөгүй өрхийн үйлдвэрлэлийн болон асаргаа халамжийн ажлууд .....	18
4.3 Алдагдсан орлого.....	18
4.4 Хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал.....	19
4.5 Хөрөнгийн эх үүсвэр .....	20
4.6 Нийт зардал ба зардлын бүлэглэл .....	21
<b>5. Хязгаарлалтууд.....</b>	<b>23</b>
<b>6. Гол зөвлөмжүүд .....</b>	<b>24</b>
<b>НОМЗҮЙ .....</b>	<b>27</b>
<b>Хавсралт: Судалгаанд ашигласан таамаглалууд .....</b>	<b>30</b>

## ХУРААНГУЙЛСАН ҮГСИЙН ЖАГСААЛТ

<b>ЖСХ</b>	Жендэрт суурилсан хүчирхийлэл
<b>ОЭЭХ</b>	Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл
<b>ГБХ</b>	Гэр бүлийн хүчирхийлэл
<b>ДХХ</b>	Дотны хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл
<b>ҮСХ</b>	Үндэсний Статистикийн Хороо
<b>НҮБХАС</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сан
<b>ТХЗ</b>	Тогтвортой Хөгжлийн Зорилтууд
<b>НЦҮТ</b>	Нэг цэгийн үйлчилгээний төв
<b>ХХӨГЗ</b>	Хувь хүний өөрөө гаргасан зардал
<b>Төг</b>	Монгол төгрөг
<b>Ам.долл.</b>	Америк доллар
<b>ДНБ</b>	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
<b>ГССҮТ</b>	Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
<b>ШХА</b>	Швейцарын Хөгжлийн Агентлаг
<b>ХЗДХЯ</b>	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам
<b>ХЭҮТ</b>	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв

## ТАЛАРХАЛ

Энэхүү судалгаанд шаардлагатай гол мэдээллээр хангаж, багц тоон мэдээ, мэдээллийг олж авахад дэмжлэг үзүүлсэн Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийнханд судлаачдын зүгээс талархаж байгаагаа илэрхийлье. Үндсэн тоон мэдээ, мэдээллийн багцаас гадна нэмэлт мэдээллүүдийг олж авахад Монгол улсын Үндэсний статистикийн хороо бидэнтэй хамтран ажиллаж, үнэлж баршгүй их хувь нэмэр орууллаа. Мөн Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хууль зүй, дотоод хэргийн яам болон Цагдаагийн ерөнхий газар тоон мэдээ, мэдээллээ хуваалцсанд талархаж байгаагаа илэрхийлье.

Энэхүү тооцоо судалгааг Монголын онцлог нөхцөл байдалтай үялдуулж, боловсронгуй болгоход үнэтэй зөвлөгөө өгсөн НҮБ-ын Хүн амын сангийн Ази, Номхон далайн бүсийн газарт баярлалаа. Эцэст нь энэ судалгааг санхүүжүүлсэн Швейцарын хөгжлийн агентлагт судлаачдын зүгээс гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

## ХУРААНГУЙ

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл (ОЭЭХ) нь дэлхий дахинаа буурахгүй, амь бөхтэй оршоор байгаа ноцтой, адармаатай асуудал бөгөөд нийгэмд газар авсан энэ асуудлыг устгах зорилтыг Тогтвортой хөгжлийн 5-р зорилтод (ТХЗ) тусгасан билээ. Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хувь хүмүүсийн сэтгэлзүй, бие махбодод сөргөөр нөлөөлөөд зогсохгүй гэр бүл, олон нийт, нийгэмд олон талын хор уршиг учруулдаг болохыг бид бүгд мэднэ. ОЭЭХ-ийн улмаас нийгэм, эдийн засагт учирч буй хохирлын өртгийг тооцож, энэ талын мэдлэгийн хүрээг өргөжүүлж, хүчирхийллийг шийдвэрлэхэд зориулсан төсвийг хуваарилахад шаардлагатай мэдээллээр шууд хангах санаачлагууд сүүлийн үед өргөжиж байна.

ТХЗ-ыг төрийн бодлогодоо тусгасан улс орнуудын нэг болох Монгол улс ОЭЭХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хууль тогтоомж, бодлогын түвшинд чухал олон өөрчлөлтүүдийг сүүлийн жилүүдэд хийсэн. Тухайлбал, Монгол Улсын Их хурал 2030 он хүртэл хэрэгжүүлэх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг 2016 онд баталсан. Үүний дараа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн найруулж (ГБХТТХ 2004) 2017 оноос хэрэгжүүлж эхлэв. Энэ хууль нь гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, түүнчлэн хүчирхийллийн хохирогчид давхар хохирол амсахаас сэргийлэхэд, хохирогч хамгаалалын болон хүчирхийлэл үйлдэгчдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн хууль болсон. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн (ГБХТТХ) хэрэгжилтийг сайжруулахаар Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийг сэргээн байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын дэргэд ГБХ-тэй тэмцэх хэлтсийг шинээр бий болгон салбар дундын зохицуулалтыг хангах чиглэлд чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Хэдийгээр хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх, төрөөс санхүүжүүлэхийг хуульчилсан ч санхүүжилт нь бэрхшээлтэй хэвээр байна.

Асуудлыг илүү гүн гүнзгий ойлгож мэдэхийн тулд НҮБ-ын Хүн амын сангийн мэргэжил, аргагүйн дэмжлэгтэйгээр Монгол улсын Үндэсний статистикийн хороо (ҮСХ) 2017 онд үндэсний түвшинд ЖСХ-ийн тархалтын судалгааг хийсэн (ҮСХ ба НҮБ-ын Хүн амын сан, 2018). Ингэхдээ эмэгтэйчүүд сүүлийн 12 сард дотно хамтрагчийнхаа зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн байдал болон амьдралынхаа аль нэг үед хүчирхийлэлд өртсөн байдлыг нарийвчлан судалсан. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (57.9 хувь) амьдралынхаа аль нэг үед хамтрагчийнхаа зүгээс үйлдсэн аль нэг төрлийн (бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, хянах зан үйл, эдийн засгийн) хүчирхийлэлд өртсөн гэж хариулсан байна. Мөн дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийллийн улмаас учирсан гэмтэл, хохирогчдын эрүүл мэндийн байдал, хөдөлмөрийн чадвараа алдсан өдрүүд болон тэдний тусламж эрэлхийлэх дадлын талаар мэдээлэл цуглуулсан болно.

Цуглуулсан мэдээллийг энэхүү судалгааны дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл (ДХХ)


нь эмэгтэйчүүд, өрх гэр бүл, олон нийт, цаашлаад улс орны эдийн засагт бүхэлд нь хэр их эдийн засгийн хохирол учруулж байгааг тооцоолоход ашиглав. Дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн аливаа хүчирхийллийн улмаас учирсан эдийн засгийн хохирлын өртгийг тооцохдоо мөнгөн дүнгээр илэрхийлж болохуйц зардлууд буюу хохирогчийн зүгээс хувиасаа гаргасан зардлууд, алдагдсан орлого, халамж тусламжийн хэрэгцээ, хөдөлмөрийн чадвар, бүтээмжийн алдагдал зэрэгт гол анхаарлаа хандуулав. Мөн гэр бүлийн хүчирхийлэл түүний дотор ДХХ-ийг шийдвэрлэхэд шаардагдах хөрөнгө, нөөцийг тооцож гаргалаа.

## ГОЛ ҮР ДҮНГҮҮД

### Судалгааны гол үр дүн:

- Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Монгол улсын нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол, сөрөг үр дагавар учруулж байна.
- Тооцоо судалгаанаас үзэхэд хүчирхийллээс үүдэлтэй нийт өртөг 601.2 тэрбум төгрөг (247 сая ам.доллар) болж байна (Зураг 1-ийг үзнэ үү). Үүнд:
  - Үйл ажиллагааны нийт зардал (үйлчилгээний үрсгал зардал) 24 тэрбум 167.9 сая төгрөг (9.9 сая ам.доллар).
  - Эс үйлдэхүйгээс үүдэлтэй нийт хохирлын өртөг 577 тэрбум төгрөг (237 сая ам.доллар) байгаа нь өнөөгийн үйлчилгээний зардлаас бараг 24 дахин их байна.
    - Үл үзэгдэх зардал хэмээн нэрлэгддэг хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал Монголд ДХХ-ээс үүдэлтэй нийт хохирлын өртгийн 90 хувийг эзэлж байна.
    - Хүчирхийлэлд өртөгсдийн алдагдсан орлого 18 тэрбум 517.4 сая төгрөг (7.6 сая ам.доллар).
    - Цалин хөлсгүйгээр ажилладаг өрхийн аж ахуй, асаргааны ажлын алдагдал 11 тэрбум 275 сая төгрөг (4.6 сая ам.доллар).
    - Хувь хүнээс гарсан зардал 6 тэрбум 592.8 сая төгрөг (2.7 сая ам.доллар) байна.
- Үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо: үйлчлүүлэгчдийн тоо өнөөгийнхөөс 75 хувиар өссөн тохиолдолд үүнд шаардагдах хөрөнгө нь эс үйлдэхүйгээс үүдэлтэй хохирлын өртгийн дөнгөж 7.3 хувьтай тэнцэх хэмжээгээр л нэмэгдэнэ. Иймд хөрөнгө нөөц нэг их үрэлгүйгээр ДХХ-ийн бүх хохирогчдод хүрч үйлчлэхийн тулд үйлчилгээг үлэмж хэмжээгээр өргөжүүлэх боломжтой болохыг судалгааны дүн харуулж байна.

Зураг 1: Өртгийн задаргаа



Эх сурвалж: Зохиогч

## ЗӨВЛӨМЖ

### Судалгааны дүнд үндэслэн гаргасан гол зөвлөмжүүд:

- Өдрөөс өдөрт газар авч буй ДХХ болон түүнээс үүдэлтэй улсын нийгэм эдийн засагт учирч буй эдийн засгийн хохирлын өртгийг бууруулахын тулд урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.
- Хүчирхийлэлд өртөгсдөд зориулсан эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх.
- Хүчирхийлэл үйлдэгчдэд зохих ял шийтгэл оногдуулж, хохирогчдийг хамгаалахын тулд цагдаа, шүүхийн байгууллагын хүчин чадавхыг бэхжүүлэх, ажилтнуудын жөндөрийн ойголт, мэдлэгийг дээшлүүлэх, жөндөрийн мэдрэмжтэй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр чадавхжуулах, үйлчилгээнд зарцуулах хөрөнгө санхүүжилтийг нэмэгдүүлэх.
- Хүчирхийллийн үр дагаврыг даван туулж, эмэгтэйчүүд, тэдний хүүхдүүдийн ахуй амьдралыг эргэн хэвийн байдалд оруулахад туслах үйлчилгээг хүртээмжтэй болгохын тулд ДХХ-ийн хохирогчдод мөнгөн дэмжлэг үзүүлэх, хохирогч эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, цаашид амьдралаа хэвийн хэмжээнд үргэлжлүүлэхэд шаардлагатай үр чадварыг олгоход чиглэсэн үйлчилгээг бий болгох.
- Монгол Улсын Засгийн газар хүчирхийллийн эсрэг үйлчилгээнд зарцуулж буй өнөөгийн санхүүжилтыг ойролцоогоор 5 дахин нэмж, улсын болон орон нутгийн жилийн төсвийн дор хаяж 1 хувийг хүчирхийлэлтэй тэмцэхэд зориулах.
- Засгийн газар Улс орны эдийн засгийн өсөлт, сайн сайхан байдалд чиглэсэн эдийн засаг, нийгмийн бодлогодоо ДХХ-ийн нөлөөллийн дүн шинжилгээг заавал тусгадаг болох.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хувийн хэвшлийн бизнесийн байгууллагуудтай хамтран ДХХ-ийн эсрэг цогц хариу арга хэмжээ авч, ДХХ-д өртсөн ажилчдад тусгай цалинтай чөлөө олгох нөхцлийг бүрдүүлэх.



- НҮБ-ын Хүн амын сан болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран хувийн хэвшлийн бизнесийн байгууллагуудад ажлын байран дахь ЖСХ, ДХХ-ээс үүдэлтэй хохирлын өртгийг судлах асуудлыг авч үзэх (Асанте нар, 2019; Вара Хорна, 2013, 2015 судалгааг харна уу).
- ТХЗ-д хүрч, ОЭЭХ-ийг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд ОЭЭХ, ядуурал болон эдийн засгийн өсөлт хоорондын нягт хамаарлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх.

## 1. ТАНИЛЦУУЛГА

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн (ОЭЭХ) бүх хэлбэрийг устгах явдлыг Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ) 5-д тусгасан. Өнөөг хүртэл энэ талаар нилээд ахиц дэвшил гарсан хэдий ч, өрх гэрийн хүрээнд, олон нийтийн газар, ажлын байранд охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл амь бөхтэй оршсоор байна. Энэхүү хүчирхийлэл, жендэрийн тэгш бус байдал нь тогтвортой хөгжлийн бусад зорилтуудад хүрэхэд саад тотгор учруулж байгаа ноцтой асуудлуудын нэг тул Тогтвортой хөгжлийн 5 дахь зорилтыг бүх нийтээр хэрэгжүүлэх нь нэн чухал байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2013 онд дэлхийн хэмжээнд хийсэн тооцоолоос үзэхэд гурван эмэгтэй тутмын нэг нь амьдралынхаа аль нэг үед хамтрагч эсвэл урьд нь хамтран амьдарч байсан этгээдийн үйлдсэн бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна (ДЭМБ, 2013). ОЭЭХ-ийг олон жилийн турш хүний эрхийн ноцтой зөрчил, нийгмийн эрүүл мэндийн асуудал болохыг хүлээн зөвшөөрч ирсэн. Харин энэ судалгаагаар ОЭЭХ нь эмэгтэй хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлөөд зогсохгүй урт, богино хугацааны олон үр дагавартай болохыг тогтоосон. Мөн хүүхэд, гэр бүл, хамт олон, ажлын байр, цаашлаад нийгэмд ч ноцтой сөрөг нөлөөтэй болохыг тогтоолоо. Иймд ОЭЭХ-ийн улмаас хувь хүн, гэр бүл, түүнчлэн бага, дунд, өндөр орлоготой улс орнуудын үндэсний эдийн засагт учруулж буй хохирлын өртөгийг тооцох явдал сүүлийн үед нэмэгдэж байна.

НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Монгол улсын Үндэсний статистикийн хороо ЭЭХ/ЖСХ-ийн хэлбэр, тархалт, шалтгаан, үр нөлөөг тогтоохоор 2017 онд үндэсний хэмжээний судалгаа хийв (ҮСХ, НҮБ-ын Хүн амын сан, 2018). Энэ судалгаа бол Монгол улсад ЭЭХ-ийн тархалтыг (тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулсан) холимог арга ашиглан судалсан анхны том хэмжээний судалгаа юм. Судалгаагаар хүчирхийллийг таслан зогсоох бодлогод нөлөөлөхүйц бодитой нотолгоо мэдээллийн суурь баазыг бүрдүүлэв. Өрхөд суурилсан судалгаагаар дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэл болон хянах зан үйл гэсэн хүчирхийллийн таван хэлбэрийг (ДХХ) судаллаа. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн талаас илүү (57.9) хувь нь хамтрагчийнхаа үйлдсэн хүчирхийллийн 5 хэлбэрээс аль нэгд эсвэл хэд хэдэн төрлийн хүчирхийлэлд амьдралынхаа аль нэг үед өртсөн байна. Мөн сүүлийн 12 сарын хугацаанд 3 эмэгтэй тутмын 1 нь (35 хувь) дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртсөн байна. Монгол эмэгтэйчүүдийн 31.2 хувь нь амьдралынхаа аль нэг үед бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байгаа нь дэлхийн дундаж үзүүлэлттэй ойролцоо байна. Судалгаагаар ДХХ-ийн улмаас эмэгтэйчүүдэд учирсан гэмтэл, түслэмж эрэлхийлэх дадал, ажил эрхлэх алдагдсан боломж зэрэг мэдээллийг цуглуулсан. Энэхүү мэдээллийг Монголд ДХХ-ээс үүдэлтэй эдийн засгийн хохирлын өртөгийг тооцоолоход ашиглав.

## 1.1 СУДАЛГААНЫ БҮТЭЦ

ОЭЭХ нь эмэгтэйчүүд, тэдний гэр бүлд төдийгүй олон нийт, бизнесийн байгууллага, нийгэмд ихээхэн хохирол учруулж, олон талын сөрөг нөлөөтэй болохыг бүгд хүлээн зөвшөөрдөг болсон. Доорх зурагт үзүүлсэн Судалгааны бүтэцэд ОЭЭХ-ээс үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хохирлын өртөгийг хувь хүн/айл өрх, олон нийт/бизнесийн байгууллага болон засгийн газар/улс орны түвшин тус бүрт тоймлон харуулав<sup>1</sup>. Мөн эдгээр түвшин тус бүрт учирч буй эдийн засаг, нийгмийн хохирлын өртөгүүд нь бүхэлдээ эдийн засгийн алдагдалд хүргэж байгааг харуулав. Хувь хүний болон өрхийн орлогын алдагдал зэрэг эдийн засгийн алдагдалууд нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Зураг 2: ОЭЭХ-ээс үүдэлтэй нийгэм, эдийн засгийн нөлөөг илтгэсэн судалгааны бүтэц



Эх сурвалж: Скривер нар, 2015

## 1.2 СУДАЛГААНЫ ТОЙМ

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс үүдэлтэй зардал, хохирлын өртгийг судалж тооцох нь Засгийн газрын зүгээс хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэгчидтэй хариуцлага тооцоход хуваарилах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын түвшинд үхүүлгэ нөлөөлөл хийхэд чухал ач холбогдолтой. Мөн хууль, бодлого, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцоход хэрэгтэй. Өртгийг судлахдаа *эс үйлдэхүйн зардал*<sup>2</sup>, *арга хэмжээний зардал*<sup>3</sup>, *эсвэл аль алийг нь* хамтад нь

- 1 Засгийн газрын зүгээс хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хүчирхийллийн нөлөөллийг арилгахад зарцуулж буй санхүүжилтийг “зардал” гэж тооцохгүйгээр харин ОЭЭХ-ээс урьдчилан сэргийлэх, эмэгтэйчүүдийг хамгаалах, хүчирхийлэгчид зохих ял шийтгэлийг оноох зэрэг Хүний эрхийг хамгаалах Засгийн газрын үүргүүдийн “биелэлт” гэж үзэхийг зөвлөмж болгож байна.
- 2 Засгийн газар ОЭЭХ-ийн асуудлыг зүй зохистой шийдвэрлэж чадаагүйн улмаас үүссэн зардлууд.
- 3 ЭЭХ-ийг шийдвэрлэхэд шаардлагатай хөрөнгө эх үүсвэр.

тооцож болно.

Энэ судалгаагаар мөн дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүд/ айл өрх болон Монголын эдийн засагт учирч буй хохирлын эдийн засгийн өртгийг тооцохын сацуу нийт хохирлын өртөгийг хүчирхийллийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний зардалтай харьцуулж харуулахыг хичээлээ.

Судалгаагаар үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг тооцоолохоос гадна эдгээр үйлчилгээнд хуваарилж буй засгийн газрын өнөөгийн зарцуулалтад үнэлгээ хийлээ. Шаардагдах хөрөнгө нөөцийн хэмжээ одоо хуваарилж буй хөрөнгөөс хол зөрүүтэй байгаагаас үзэхэд ДХХ-ийг шийдвэрлэх арга хэмжээг нэн яаралтай авах шаардлагатай нь илт байна.

### 1.3 СУДАЛГААНЫ ЗОРИЛТУУД

Судалгааны ерөнхий зорилгод хүрэхийн тулд дараах 3 зорилтыг хэрэгжүүлэв. Үүнд:

- 1) Дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллээс үүдэн эмэгтэйчүүд/айл өрхөд учирсан хохирлын эдийн засгийн өртгийг тооцох, ингэхдээ хөдөлмөрийн зах зээл дэх бүтээмжийн алдагдал, Монгол улсын эдийн засагт үзүүлэх нөлөөг хамтад нь тооцох,
- 2) ДХХ-ээс урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээ авахад шаардагдах хөрөнгийг тооцох.
- 3) ДХХ-ээс үүдэлтэй хохирлын эдийн засгийн өртгийн талаарх үндэсний мэргэжилтнүүд, ажлын хэсгийн гишүүд, түнш болон оролцогч талуудын мэдлэгийг дээшлүүлэх.

Эхний зорилтыг хэрэгжүүлэхээр дараах тооцоог хийв. Үүнд: А) Хувь хүн өөрөөсөө гаргасан зардал (ХГЗ), Б) Өрхийн орлогын алдагдал/Үндэсний алдагдал, В) Нийт алдагдалыг (Хүснэгт 1-ийг үзнэ үү) тооцов. Хоёрдахь зорилтыг хэрэгжүүлэхийн тулд ГБХ-ийн хохирогчдод эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлэхэд гарч буй зардлыг тооцож, цаашид шаардлагатай санхүүжилтийг тооцооллоо.

#### Хүснэгт 1: Эс үйлдэхүйн өртөг

Зардлын ангилал	Зардлын төрлүүд
А) Хувь хүн өөрөөсөө гаргасан зардлууд	Эрүүл мэндийн үйлчилгээ
	Нийгмийн үйлчилгээ
	Гэр бүл салалт
Б) Өрхийн орлогын алдагдал / Үндэсний алдагдал	Цалин хөлсгүйгээр ажилладаг өрхийн аж ахуй, асаргааны ажлын алдагдал
	Алдагдсан орлого
	Хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал
В) Нийт алдагдал	Нийт зардал
	Өртгийн хуваарилалт
	ДНБ-нд эзлэх хувь

Эх сурвалж: Зохиогч

Гуравдахь зорилтын хүрээнд Улаанбаатар хотод 2019 оны 10 дугаар сарын 17-нд Доктор Мринал Чадхагийн зохион байгуулсан зөвлөлдөх семинарт Үндэсний мэргэжил арга зүйн ажлын хэсэг оролцлоо. Семинарын үеэр тусгайлан боловсруулсан гарын авлага ашиглан өртөг тооцох төрөл бүрийн аргачлалууд, зардлын ангилалыг оролцогчдод зааж, шинэ мэдлэг олгон, чадавхижуулж, идэвхитэй оролцоог хангав. Гол оролцогч талууд Үндэсний мэргэжил арга зүйн ажлын хэсэгтэй хамтран өртгийн дүн шинжилгээний үзүүлэлтүүдийг эцэслэж тодорхойлсон нь тооцооллыг өөрсдөө хийж, өртөг тооцох аргачлалын талаарх мэдлэгээ гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа. Мөн судалгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг нарийвчлан тохирч, товлосон хугацаандаа ажлаа бүрэн хэрэгжүүлэв.

## 2. НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 2.1 НИЙГЭМ, УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

#### 2.1.1 Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал

Зүүн хойд Азийн төв хэсэгт байрладаг Монгол улс өргөн уудам газар нутагтай, 3,314,070 хүн амтай (ҮСХ, 2020 а). Хүн амын ихэнх нь үржил шимтэй бэлчээр, газар тариалангийн бүс нутаг бүхий тээвэр дэд бүтэц хамгийн сайн хөгжсөн хойд болон төв хэсэгт төвлөрөн амьдардаг. Засаг захиргааны хувьд 21 аймагтай. Аймаг нь сумдад, сум нь багт хуваагддаг. Мөн нийслэл Улаанбаатар хот нь бие даасан засаг захиргааны статустай, есөн дүүрэгтэй. Ажилгүйдлийн улмаас хөдөө орон нутгаас Улаанбаатарт шилжин ирэх айл өрхийн тоо улам бүр өсч, нийслэл хот нь улам өргөжин тэлж байна. Гэвч хөдөө аж ахуй, ойн аж ахуй Монгол улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна. 1960-аад оноос хойш Монгол улс нүүрс, зэс, алт, мөнгө зэрэг янз бүрийн ашигт малтмалын нөөцийг олборлоход анхаарч байна. Уул уурхай, ноолуурын үйлдвэрлэл, аялал жуулчлал нь эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулж буй шинэ салбарууд юм. Мөн 1990 оноос хойш үйлчилгээний салбар эрчимтэй хөгжиж байна.

2019 оны 4-р улирлын байдлаар Монгол улсын хөдөлмөрийн (15-аас дээш) насны хүн ам 2,132,102 байв (ҮСХ, 2020 б). Ажиллах хүч нэг сая гаруй хүн (1,293,579 хүн цалин авч, ашиг олох зорилгоор бараа үйлдвэрлэл, ажил үйлчилгээний салбарт ажиллаж байна), ажиллах хүчний хамрагдалт 60.7 хувь - үүнд эрэгтэйчүүд 69.0 хувь, эмэгтэйчүүд 53.2 хувьтай байна. 2019 онд хөдөлмөр эрхэлж буй нийт иргэдийн дийлэнх нь (52.5 хувь) үйлчилгээний салбарт ажиллаж байсан бөгөөд 26.1 хувь нь хөдөө аж ахуй, 21.4 хувь нь үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна. 2020 оны 1-р сард эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүд (бүртгэгдсэн ажилгүй иргэдийн 53 хувь) ажилгүй байна.

#### 2.1.2 ОЭЭХ-ийн талаарх хууль, бодлого

*Гэр бүлийн хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх нийгмийн хэм хэмжээ нь хүчирхийллийг сонссон ч сонсоогүй, мэдсэн ч мэдээгүй мэт байх, хүчирхийлэлд өртсөн ч чимээгүй байх зуршлыг бий болгодог бөгөөд ингэснээр илрүүлэлт буурах, хууль эрх зүйн болон хохирогч хамгааллын тогтолцоонд эргэлзэх хууль эрх зүйн хамгаалалт болон бусад үйлчилгээг хамгийн бага ашиглах нөхцлийг бий болгож байна (Оюунчимэг ба Баярцэцэг, 2018, 10х.)*

Монгол улс бол 2030 онд хүрэх Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-уудыг урт хугацааны хөгжлийн бодлогодоо тусгасан анхны орнуудын нэг юм (Монгол Улсын Засгийн газар, 2019). 2011 онд баталсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2013-2016)-ийг Засгийн газар 2013 онд, Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний Хөтөлбөрийг 2017 онд батлав. Үүний дараа 2016 онд Монгол Улсын Их Хурал 2030 он хүртэл хэрэгжүүлэх

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баталлаа. ҮСХ яамдуудтай хамтран ЖСХ/ЭЭХ-ийн талаар хүйсээр ангилсан мэдээллийг цуглуулах шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулав. Гэвч үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх, санхүүжитийг нэмэгдүүлэхэд эдгээр тоо мэдээллийг ашиглах нь хязгаарлагдмал хэвээр байна.

Монгол улс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга (ГБХТТХ 2004)-ыг 2016 оны 12 сард батлан 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хуулийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)-ээс урьдчилан сэргийлэх, түүнд хариу арга хэмжээ авах, мөн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах, хүчирхийллийн үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгоход анхаарч байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (ГБХТТХ)-ийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн (ХЗДХ) сайдаар ахлуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийг дахин шинээр байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын дэргэд ГБХ-тэй тэмцэх хэлтсийг бий болгосноор салбар дундын зохицуулалтыг хангах, ГБХТТХ-ийг хэрэгжүүлэхэд ахиц дэвшил гарсан. ГБХТТХ нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хуулиудтай харилцан уялдаатай хэрэгждэг. Засгийн газраас ГБХТТХ-ийг хэрэгжүүлэхэд ХЗДХЯ манлайлан ажиллаж, уг хуулийг хэрэгжүүлэх журмуудыг боловсруулж, холбогдох яамд мөн хариуцсан салбарууддаа уг хуулийг хэрэгжүүлэх журмуудыг боловсруулж, хэрэгжүүлж байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ) ГБХТТХ-ийн хэрэгжилтийн байдалд ИНБ-ын хөндлөнгийн үнэлгээг хоёр удаа 2018 болон 2019 онуудад тус тус хийсэн. Цагдаагийн байгууллагын чиг үүрэгт 2018 онд хийсэн үнэлгээгээр ГБХ-тэй тэмцэх чиглэлээр олон тооны тэргүүн туршлага, стандарт, тодорхой санаачлагууд хэрэгжүүлсэнийг сайшаан магтаж, цаашид чадавхыг бэхжүүлж, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн байна. 2019 оны үнэлгээгээр хүчирхийлэл үйлдэгч нарт зориулсан албадан сургалт засан хүмүүжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг шалгасан байна. Энэ чиглэлд мэдэгдэхүйц ахиц гарсан ч сургалт засан хүмүүжүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж нь чанарын өөрчлөлт хийх түвшинд хараахан хүрээгүй байгааг онцолжээ. Эдгээр үнэлгээний дүнд үндэслэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, ХЗДХЯ-нд өргөн бариад байна. Бодлогын түвшинд 2008-2021 онд хэрэгжүүлэх Үндэсний хөгжлийн стратегид ГБХ-ийг бууруулах асуудлыг тусгаж, Монгол Улс 2014 онд “НҮБ-ын АМЛАЛТ” санаачлагад гарын үсэг зурж, ГБХ-ийг гэмт хэрэгт тооцож, ЭЭХ-ийг нэн даруй таслан зогсоох олон улсын санаачлагад нэгдсэн юм. Эдгээр хууль тогтоомж, бодлогын баримт бичиг нь Монголын нийгэмд ЖСХ, ГБХ-ийг үр дүнтэй шийдвэрлэх шаардлага байгааг онцолдог.

Нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлэхэд төсвийг үр дүнтэй хуваарилах нь ЭЭХ-ийг шийдвэрлэхэд чухал хэдий ч санхүүжилтийн байдал хязгаарлагдмал, хүндрэлтэй хэвээр байна. 1995 оноос хойш ХЭҮТ бусад иргэний нийгмийн байгууллагуудын хамтаар гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод эрх тэгш, аюулгүй байдлыг хангасан тусламж үзүүлэхийг засгийн газраас шаардсаар ирсэн. ХЭҮТ урьдчилан сэргийлэх, хамгаалах тогтолцоог улсын хэмжээнд бий болгоход өөрийн хувь нэмрээ оруулан, ГБХ-ээс хамгаалах 5 байрыг улсын хэмжээнд ажиллуулж байна. Мөн НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын дэмжлэгтэйгээр Засгийн газар 2009 онд Улаанбаатар хотод

хүчирхийллийн хохирогчдод утсаар зөвлөгөө өгдөг, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн үйлчилгээ, хамгааллын үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээг цогцоор нь үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний 3 төв байгуулсан байна.

НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Засгийн газар 2013-2014 онд Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймагт нэг цэгийн үйлчилгээний гурван төвийг нэмж байгуулан, хамгаалах байруудыг бусад аймгуудад нэмж байгуулахаар ажиллаж байна. 2017 онд хийсэн ЖСХ/ ЭЭХ-ийн тархалтын судалгаа (ҮСХ ба НҮБ-ын Хүн амын сан, 2018)-ны дүнд үндэслэн Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад ЖСХ-тэй тэмцэх” төслийн хүрээнд дахин 7 аймаг, Улаанбаатар хотын 2 дүүрэгт нэг цэгийн үйлчилгээний 9 төвийг нэмж байгуулав. Энэ нь хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдэд үзүүлэх НҮБ-ын нэн шаардлагатай үйлчилгээний багцыг хэрэгжүүлэхэд чухал алхам болж байна (НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, НҮБ-ын Хүн амын сан, ДЭМБ, НҮБХХ, НҮБМБГХ, 2015 он).

## **2.2 МОНГОЛ УЛС ДАХЬ ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ**

Хүчирхийлэлтэй холбоотой тоо баримтын суурь баазыг бий болгохын тулд НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Үндэсний статистикийн хороо (ҮСХ) 2017 онд ЖСХ/ЭЭХ-ийн онцлог шинж чанар, нөлөөлөл тархалтын талаарх анхны томоохон судалгааг үндэсний түвшинд хийж, үр дүнг үндэсний хэмжээнд түгээсэн (2018). Энэхүү үндэсний судалгаа нь тоон болон чанарын гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд тоон судалгаанд ДЭМБ-ын Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд ба гэр бүлийн хүчирхийллийн олон улсын судалгааны аргачлалыг, чанарын судалгаанд бусад аргачлалуудыг авч ашиглав. Уг судалгаагаар ЭЭХ-ийн төрөл бүрийн хэлбэрүүд, тэдгээрийн тархалт, тохиолдол; ДХХ нь эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буй байдал, өөр бусад ямар үр дагавартайг үнэлж, харилцан хамаарлыг нь тооцож; ДХХ-ээс хамгаалах, эрсдэлд оруулж буй хүчин зүйлийг судалж; эмэгтэйчүүдийн тусламж эрэлхийлэх, хүчирхийллийг даван туулах арга замуудыг судаллаа. Чанарын судалгаагаар асуудлыг улам гүнзгийрүүлэн судалж, НҮБ-ын ТХЗ-ын үзүүлэлтүүд, ялангуяа ТХЗ 5 (5.2.1 ба 5.2.2) дахь үзүүлэлтийг Монголд тооцох мэдээллүүдийг цуглуулав.

Эхлээд, тоон судалгааны хүрээнд хүн амд суурилсан өрхийн судалгаа явуулж Монгол улсын 21 аймаг, 9 дүүргийн (15-64 насны) 7,920 эмэгтэйтэй ярилцлага хийв. Үүний дараа тоон судалгаанаас гарах боломжгүй байсан нэмэлт мэдээллийг цуглуулахын тулд 392 иргэнтэй 64 зорилтот бүлгийн ярилцлага, 87 гүнзгийрүүлсэн ярилцлага, 59 мэргэжилтнүүдийн ярилцлагыг зохион байгуулав. Өрхийн судалгаагаар эмэгтэйчүүдээс асуулга авч, бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэл болон хянах зан үйл гэсэн хүчирхийллийн 5 хэлбэрийг судлав. Ингэхдээ эмэгтэйчүүд амьдралынхаа аль нэг үед хүчирхийлэлд өртсөн эсэх, мөн сүүлийн 12 сард хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эсэхийг судлав. Энэхүү судалгаанд хамтрагч гэдэгт гэрлэсэн, хамтран амьдарч буй, тусдаа амьдардаг, салсан эсвэл бэлэвсэрсэн ойр дотны эрэгтэй хамтрагч нарыг багтааж тооцов.

Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн талаас илүү хувь (57.9%) нь амьдралынхаа аль нэг үед хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл (бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, хянах зан



үйл, эдийн засгийн хүчирхийлэл)-д өртсөн байна. 35 хувь нь ДХХ-ийн ямар нэгэн хэлбэрт сүүлийн 12 сарын хугацаанд өртжээ. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/ эсвэл бэлгийн хүчирхийллийг олон улсад харьцуулж, ашиглах хандлагатай байдаг бөгөөд хүчирхийллийн эдгээр төрлүүдийн тодорхойлолт нэлээд тодорхой, түгээмэл байдгыг харгалзан үзэж, хүчирхийллээс үүдэлтэй зардал, хохирлын өртгийг тооцоходоо бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой өртгийг онцолж судаллаа. Монголд эмэгтэйчүүдийн бараг гуравны нэг (31.2 хувь) нь амьдралынхаа аль нэг үед бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байгаа нь дэлхийн дундаж түвшинээс бага зэрэг давсан үзүүлэлт юм (30 хувь; ДЭМБ, 2013). Сэтгэл санаа болон эдийн засгийн хүчирхийлэл нь эмэгтэйчүүдэд ихээхэн нөлөөлдөг бөгөөд энэ төрлийн хүчирхийллийг хэмжихэд хүндрэлтэй байдаг. Гэвч судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүдийн 40.3 хувь нь амьдралынхаа аль нэг үед сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн гэж хариулсан бол 22.4 хувь нь сүүлийн 12 сард сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн гэж хариулжээ. Мөн өмнө нь хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай эмэгтэйчүүдийн 19.9 хувь нь амьдралынхаа аль нэг үед эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байна.

Судалгаагаар ДХХ-ийн улмаас эмэгтэйчүүдэд учирсан гэмтэл, тэдний эрүүл мэндийн байдал, алдагдсан ажлын өдрүүд, тусламж эрэлхийлэх дадлын талаарх мэдээллийг цуглуулав. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон /эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бараг тал нь (42.8 хувь) хүчирхийллийн улмаас гэмтэл бэртэл авчээ. Тэдний ихэнхи нь хүнд ноцтой гэмтсэн байна. Хамтрагчийн үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд өөрийн эрүүл мэндийг “муу” эсвэл “маш муу” гэж дүгнэх хандлагатай байгаа бөгөөд тэдэнд сэтгэцийн эрүүл мэндийн өөрчлөлтийн хэд хэдэн шинж тэмдэг илэрч, амиа хорлох бодол төрөх явдал түлхүү тохиолдсон байна. Судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүдийн ихэнх (73.5 хувь) нь хамтрагчийнхаа үйлдсэн хүчирхийлэлд өртсөнөө хэн нэгэнд ярьсан байна. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн үедээ тусламж эрэлхийлсэн эсэхийг асуухад бараг дөрвөн эмэгтэй тутмын нэг нь (23.9 хувь) нь цагдаад хандсан гэжээ. Арван эмэгтэй тутмын нэг (13.2 хувь) нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад, 12.5 хувь нь лам, шашны тэргүүнд хандсан бол хамгаалах байр болон бусад тусламж үйлчилгээний байгууллагад маш цөөн тооны эмэгтэйчүүд (1.5 хүрэхгүй хувь) хандсан байна. Мөн амьдралын аль нэг үед ДХХ-ийн улмаас алдагдсан ажлын өдрүүдийн талаархи мэдээллийг цуглуулав. 2007 онд хийсэн ГБХ-ээс үүдэлтэй зардал, хохирлын өртгийг тооцсон бага хэмжээний судалгааг (ЮНЕСКО, 2007) улам өргөжүүлж, Монголд ДХХ-ээс үүдэн эмэгтэйчүүдэд учирч буй зардал, хохирлын өртгийг тооцоход уг мэдээллийг ашиглав. Энэхүү өртгийн судалгааны дүнг Д.Оюунчимэг, Ж.Баярцэцэг нарын 2018 онд хийсэн ЖСХ-ийн хохирогчдод зориулсан үйлчилгээнд хуваарилсан төсвийн судалгаанд нэмэлт мэдээлэл болгон ашиглалаа.

## 3. АРГАЧЛАЛ

Энэ хэсэгт Дувури нарын судлаачдын 2019 онд хийсэн судалгаанд суурилсан ЖСХ/ЭЭХ-г шийдвэрлэхэд шаардагдах хөрөнгө, эх үүсвэр, хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал, цалин хөлсгүйгээр ажилладаг өрхийн аж ахуй, асаргааны ажлын алдагдал, алдагдсан орлого, хувиасаа гаргасан зардлыг тооцоолоход ашигласан аргачлалын талаар дурдсан болно. 2017 оны ЖСХ/ЭЭХ-ийн судалгааны ерөнхий мэдээллийг зардлын тооцоо хийхдээ ашигласан бол энэхүү судалгаанд ЖСХ/ЭЭХ-ийн судалгаанд тусгагдаагүй агуулга болон 2017 оны Ажиллах хүчний судалгаа (1212.mn), өмнөх ижил төстэй судалгааны үр дүн, Монгол Улс дахь НҮБ-ын Хүн амын сангийн өгсөн мэдээлэл /гэхдээ үүгээр хязгаарлагдаагүй/ зэрэг бусад мэдээллийн эх үүсвэрийг ашиглав. Зардал бүрийн төрлийг тооцоолоход ашигласан аргачлал болон мэдээллийн эх үүсвэрийг доор дурдсан.

### 3.1 ХУВЬ ХҮН ӨӨРӨӨ ГАРГАСАН ЗАРДЛУУД

#### 3.1.1 Эрүүл мэндийн зардлууд

Сүүлийн 12 сарын хугацаанд дотно хамтрагчийнхаа зүгээс үйлдсэн бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас эрүүл мэндийн асаргаа, үйлчилгээ авах шаардлагатай бэртэл, гэмтлийн талаар мэдэгдсэн эмэгтэйчүүдийн хувиасаа гаргасан эрүүл мэндийн зардлыг тооцов. Эдгээр тооцоог дор дурдсан 2017 оны ЖСХ/ЭЭХ-ийн судалгааны (805а ба 805б)-р асуулгад үндэслэн хийсэн болно<sup>4</sup>. Үүнд:

*Таны амьдралын аль нэг үед таны нөхөр/хамтран амьдрагч тань танд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах шаардлагатай болтол хүнд (ямар нэг) гэмтэл учруулж байсан уу? Сүүлийн 12 сард ийм явдал тохиолдсон уу?*

ДХХ-ийн талаар мэдээлээгүй, тусламж эрэлхийлэхгүй байх тохиолдлуудаас үүдэн дээрх асуулгад “Тийм” гэж хариулсан судалгаанд оролцогчийг эрүүл мэндийн үйлчилгээ авсан гэж үзэв. Энэхүү таамагт тусламж эрэлхийлэхгүй байх зан үйлийг мөн тодорхой хэмжээнд тооцож үзсэн. 2017 оны ЖСХ/ЭЭХ-ийн судалгаа нь хүчирхийлэлд өртөгчид хэр их тусламж хүссэн, эрэлхийлсэнийг бус харин зөвхөн тусламж хүсэх, эрэлхийлэх байдалд чиглэсэн бөгөөд хувиас гарах эрүүл мэндийн зардлыг тооцохдоо Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв (ГССҮТ)-өөс авсан тоон мэдээллийг ашигласан. ГССҮТ-өөс авсан тоон мэдээлэлд анхан шатны тусламж үйлчилгээ, сэтгэлзүйн давтан зөвлөгөө, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх эмчилгээ, мэс заслын мэдээллүүд багтсан.

ГССҮТ<sup>5</sup>-аас өгсөн мэдээллийн дагуу 2017 онд нийт 1,054 эмэгтэй эрүүл мэндийн үйлчилгээнд

4 2017 оны ЖСХ / ЭЭХ-н судалгааны асуулгыг [http://web.nso.mn/nada/index.php/catalog/117/related\\_materials-холбоосноос](http://web.nso.mn/nada/index.php/catalog/117/related_materials-холбоосноос) харж болно

5 Эдгээр тоон мэдээллийг эхний семинарын үеэр ГССҮТ-өөс хэвлэгдээгүй албан ёсны эх сурвалжаас өгсөн.

хамрагдсанаас сүүлийн 12 сарын хугацаанд 65.9 хувь буюу 694,694 эмэгтэй тус бүр 4,250 төгрөг (1.7 ам.доллар<sup>6</sup>) зарцуулан дунджаар 4 удаагийн зөвлөгөө авч эмчилгээ хийлгэжээ. Үлдсэн 30.4 хувь буюу 320 эмэгтэй анхан шатны тусламж авсан бөгөөд дунджаар 4,250 төгрөг (1.7 ам.доллар)-ийн зардал хувиасаа гарган нэг удаагийн зөвлөгөө авсан гэж тооцов. Түүнчлэн 21 эмэгтэй (2 хувь) дунджаар 1,738,650 төгрөгийг (714.2 ам.доллар) мэс засал хийлгэхэд зарцуулсан бол 19 (1.8 хувь) нь мэс заслын бус хэвтэн эмчлүүлэхэд 800,000 төгрөг (328.6 ам.доллар) зарцуулжээ. ЖСХ/ЭЭХ-ийн 2017 оны судалгаагаар 2017 онд тусламж эрэлхийлсэн хүчирхийлэлд өртөгчид ижил байгууллага буюу ГССҮТ-д хандан ижил хэмжээний ижил өртөгтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан гэж дурдсан байна.

### 3.1.2 Нийгмийн үйлчилгээ авах зардал

Энэхүү судалгаанд хүчирхийлэлд өртөгчдийн хувиасаа гаргасан зардлын тооцоог гаргахын тулд үйлчилгээ авсан гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн нарийвчилсан тоо баримт бүхий 2018 онд Дандарын Оюучимэг, Жигмиддашийн Баярцэцэг нарын өмнө нь хийсэн үйлчилгээний зардлын тайланг ашиглав. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 2,316 хохирогчид 2017 онд хамгаалах байр болон<sup>7</sup> 108 тусламжийн төвд хандсан байна. Үүнээс гадна, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1,612 хүн нэг цэгийн үйлчилгээний төвд ханджээ<sup>8</sup>. Хүчирхийлэлд өртсөн нийт 3,228 эмэгтэй 2017 онд нийгмийн үйлчилгээнд хамрагдсан байна (Оюунчимэг ба Баярцэцэг, 2018).

Монгол Улс дахь НҮБХАС-аас өгсөн дараах зардлуудын дүнг эдгээр 3,228 эмэгтэйчүүдийн суурь зардал болгон судалгаанд ашиглав. Үүнд: Эрүүл мэндийн даатгал (45,000 төгрөг буюу 18.5 ам.доллар), эм бэлдмэл (35,000 төгрөг буюу 14.4 ам.доллар), унаа, тээврийн зардал (17,500 төгрөг буюу 7.2 ам.доллар), мөн 30,000 төгрөг (12.3 ам.доллар)-ын баримт бичиг дахин гаргуулахтай холбоотой торгуулийн төлбөр, 20,000 төгрөг (8.2 ам.доллар)-ын баримт бичиг дахин гаргуулах төлбөрийг тус тус багтаасан баримтжуулах зардал (50,000 төгрөг буюу 20.5 ам.доллар), нүүх эсвэл гэр барих зардал (80,000 төгрөг буюу 32.9 ам.доллар), ТҮЦ машинаас лавлагаа (нийтийн үйлчилгээ) авах төлбөр (1,000 төгрөг буюу 0.4 ам.доллар), шилжилт хөдөлгөөн хийлгэх зардал (7,500 төгрөг буюу 3 ам.доллар), харилцаа холбоо, эрүүл ахуйн бүтээгдэхүүн (30,000 төгрөг буюу 12.3 ам.доллар)-д тус тус зарцуулсан байна. Хүүхэдтэй эмэгтэйчүүдийн эзлэх хувь жингийн талаархи мэдээлэл байхгүй байгаа бөгөөд 2017 оны ЖСХ/ЭЭХ-ийн судалгаанд хамгийн багадаа нэг хүүхэдтэй (80.8 хувь) хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүд судалгаанд оролцсон байв (ҮСХ, НҮБ-ын Хүн амын сан, 2018). Хувийн сургуульд хүүхэд нь суралцдаг хүүхдийн хувь хэмжээний талаархи мэдээлэл дутагдалтай байгаа тул хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн тал хувийнх нь хүүхэд нь 2,000,000 төгрөг (821.5 ам.доллар)-ийн зардал бүхий хувийн сургуульд суралцдаг гэж тооцоолов. Зардлыг инфляцад тохируулан тооцно.

6 1 ам.долларыг [exchangerates.org.uk](http://exchangerates.org.uk)-ийн 2017 оны мэдээлэлд үндэслэн 2434.4849 төгрөгтэй тэнцүүгээр тооцсон.

7 ХЭҮТ-ийн хамгаалах байрууд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг болон Төв аймагт, Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа хамгаалах байр Хан-уул дүүрэгт байрладаг.

8 НҮБХАС-ийн санхүүжилтээр байгуулсан 6 НЦҮТ бий. Эдгээрээс 3 нь Улаанбаатар хотод байна. Үүнд: Гэмтэл Согор Судлалын Үндэсний төв, Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв Шүүх эмнэлэг. Бусад 3 нь орон нутагт байрладаг: Баянхонгор (ТББ түшиглэсэн), Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэгт, Завхан аймгийн Цагдаагийн газарт.

### 3.1.3 Гэрлэлт цуцлуулах зардал

Гэр бүлээ цуцлуулсан эмэгтэйчүүдийн 69.81 хувь нь амьдралынхаа аль нэг үед ямар нэг байдлаар ДХХ-д өртсөн байдаг нь Монгол Улсад салалтыг асуудлыг шийдвэрлэх гол арга болгон ашигладгыг харуулж байна. Иймд эмэгтэйчүүдийн хувьд салалттай холбоотой эдийн засгийн хохирлыг тооцох оролдлого хийсэн.

Захиргааны бүртгэлд шүүхээр гэр бүл цуцлуулсан олон тооны хэргүүд бүртгэгдсэн (Дандарын Оюучимэг, Жигмиддашийн Баярцэцэг, 2018) бөгөөд 2017 онд эцэг эх байх эрх хассан 24 шийдвэрийг оролцуулаад шүүхээр гэр бүл цуцлуулах 2,791 хэрэг шийдвэрлэсэн (Дандарын Оюучимэг, Жигмиддашийн Баярцэцэг, 2018) байна. ДХХ-ээс үүдэн гэр бүлээ цуцлуулсан тохиолдлын тоо баримт, мэдээлэл байхгүй байгаа тул тооцоолол хийхдээ 2017 оны ЖСХ/ЭЭХ-ийн судалгааг ашиглав. Сүүлийн 12 сарын хугацаанд ДХХ-ийн хүчирхийлэлд өртсөний улмаас гэр бүлээ цуцлуулсан эмэгтэйчүүдийн хувь хэмжээг амьдралдаа ямар нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртөж байсан гэр бүлээ цуцлуулсан хүмүүсийн хувь хэмжээнд үндэслэн гаргасан (69.8 хувь).

Гэр бүл цуцлуулахтай холбоотой зардлыг Монгол Улс дахь НҮБХАС-ийн өгсөн 2019 оны гэрлэлт цуцлуулах зардлын мэдээллийг ашиглан дараах байдлаар тооцов. Үүнд: Гэр бүл цуцлуулах өргөдөл гаргах (70,200 төгрөг буюу 28.8 ам.доллар), хүүхдийн мөнгөн тэтгэмж авах өргөдөл гаргах (70,200 төгрөг буюу 28.8 ам.доллар), хүүхэд асран хамгаалах өргөдөл гаргах (52,650 төгрөг буюу 21.6 ам.доллар), нотариатын төлбөр (3,500 төгрөг буюу 1.4 ам.доллар), баримт бичиг хэвлэх болон олшруулах төлбөр (10,000 төгрөг буюу 4.1 ам.доллар), өмгөөллийн төлбөр (1,200,000 төгрөг буюу 492.9 ам.доллар), тодорхойлолт болон архивын лавлагаа (5,500 төгрөг буюу 2.3 ам.доллар)-ны зардлыг тус тус оруулан тооцов. Гэр бүл салалтын улмаас гарсан хохирлын тооцоог 2019 оны мэдээллийн тухайд инфляцад тохируулан тооцно. Шүүхээс эцэг эх байх эрхийг хассан 24 шийдвэрийн хувьд хүүхдийн мөнгөн тэтгэмж авах өргөдөл гаргах болон хүүхэд асран хамгаалах өргөдөл гаргах зардлыг оруулалгүй тооцсон болно. Мэдээлэл байхгүй тул хамтын эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийн өөрт оногдох хувийг авах хүсэлт болон шүүхийн хураамжийг мөн тооцоололд оруулаагүй.

### 3.2 ЦАЛИН ХӨЛСГҮЙГЭЭР АЖИЛЛАДАГ ӨРХИЙН АЖ АХУЙ, АСАРГААНЫ АЖЛУУД

Эмэгтэйчүүдийн асаргаа халамжийн ажлын цаг болон ДХХ-ийн хувь хэмжээг ижил төстэй бусад Улс орнуудын эмэгтэйчүүдийн дундаж алдагдсан хоногуудыг тооцох замаар Монгол Улсын эмэгтэйчүүдийн бусдыг асран халамжлан өнгөрөөдөг цаг хугацааг тооцох оролдлого хийсэн. ДХХ-ийн дарамт шахалтын улмаас хийж гүйцэтгэдэг асран халамжлах ажлын зардлыг тогтоосон цөөн тооны улс орнуудын боломжит мэдээллийг үнэлэхэд Гана Улс хамгийн ойролцоо улсаар тогтоогдсон болно.

Учир нь Монгол Улсад эмэгтэйчүүд хүүхэд, ахмад настан, өвчтэй хүмүүсийг асран халамжлах, ирсэн зочдод үйлчлэхэд 3.4 цагийг, гэр орны ажил хийхэд 0.9 цаг зарцуулдаг (ҮСХ, 2015) бол Гана Улсад эмэгтэйчүүд гэр орны ажил, бусдыг асран халамжлахад дунджаар 3 цаг 29 минут зарцуулдаг байна (Гана Улсын статистикийн алба, 2009). ДХХ-д өртсөн түвшин нь хоёр улсад мөн ижил байгаа юм. Монгол Улсад сүүлийн 12 сарын хугацаанд эмэгтэйчүүдийн 35 хувь нь дотнын

хамтрагчийнхаа ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртсөн байна. Үүнд: бие махбодын, бэлгийн, эдийн засгийн, сэтгэл санааны хүчирхийлэл болон хянах зан үйл (ҮСХ ба НҮБХАС, 2018) гэсэн хүчирхийллийн 5 хэлбэр орно. Гана Улсад ойролцоогоор эмэгтэйчүүдийн 43 хувь нь сүүлийн саруудад хамтрагчийнхаа аливаа хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн байна (Асанте нарын судалгаа, 2019). Энэхүү ижил төстэй бусад орны дүн дээр суурилан тухайн нэг орны ойролцоо үр дүнг багцаалан тооцох аргачлал нь өртөг зардлын судалгааны бүтээлүүдэд түгээмэл байдаг (Феорон ба Хоэффлер, 2014; Рагахендра, Чадха ба Дуввури, 2018).

Асанте нарын 2019 оны судалгаанд дурдсанаар Гана Улсад ДХХ-д өртөж байсан эмэгтэйчүүдийн 15 хувь нь дунджаар 21 хоног бусдыг асран халамжлах ажил хийдэг гэж мэдэгдсэн байв. Монгол Улсын хувьд цалин хөлсгүй ахуйн ажил хөдөлмөр болон бусдыг асран халамжлах ажил хийсэн өдөр хоногийг тооцохдоо ижил хувь хэмжээ болон дундаж өдөр хоногийг ашигласан. Тооцоолсон өдрүүдийн мөнгөн дүнг тогтоохын тулд Монгол Улсад мөрддөг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ашигласан болно.

### 3.3. АЛДАГДСАН ОРЛОГО

ЖСХ/ЭЭХ-ийн судалгааны “Амьдралдаа хамтрагчийнхаа зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас ажиллаж хөдөлмөрлөж чадаагүй ажлын хоногууд” хэмээх (907 а) асуулгыг ашиглан өрхийн орлогын алдагдлыг тооцож улсын хэмжээнд шилжүүлэн тооцсон. Сүүлийн 12 сард ажилдаа явж чадаагүй ажлын өдрүүдийг тооцоолохын тулд сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн ажил хөдөлмөр эрхэлдэг хохирогчийн сүүлийн 12 сарын хугацаанд бүртгэгдсэн ажилдаа явж чадаагүй ажлын өдрүүдийг тооцоолсон. Сүүлийн 12 сард дотно хамтрагчийнхаа зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн ажил хөдөлмөр эрхэлдэг хохирогч 365 хоног ажилдаа явж чадаагүй бол эдгээр өдрүүдийн тоо жилийн хамгийн их ажлын өдрийн тоо болох 250 хоног хүртэл бууруулан тооцно. Хэрэв судалгаанд оролцогч энэхүү асуултанд “мэдэхгүй байна/ санахгүй байна” гэж хариулбал жишээ болгон ажилдаа явж чадаагүй ажлын хоногуудын дундаж тоог оруулна. Хэрэв хүчирхийлэлд өртсөн эмэгтэй асуултанд хариулахаас татгалзсан бол мэдээллийг судалгаанд оруулахгүй хасна.

ЖСХ/ЭЭХ-ийн 2017 оны судалгаанд хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн ажил мэргэжил, ажиллаж буй салбарын талаар мэдээллийг цуглуулсан боловч цалингийн талаарх мэдээллийг цуглуулаагүй байна. Европын Холбооны Ажиллах хүчний 2017 оны судалгааны мэдээллийн санд нас, байршил, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал, мэргэжил, ажиллаж буй салбарыг харгалзан үзэх замаар цалин, хөлсийг нарийвчлан судалсан байна. Гэвч Ажиллах хүчний судалгааны мэдээллийн санд маш цөөн тооны загвар байсан учир эдгээр шинж чанаруудад үндэслэн цалин хөлсийг ерөнхийлөн тогтоох боломжгүй байв. Зөвхөн ажил мэргэжил, ажиллаж буй салбарыг харгалзан цалин хөлсийг тогтоох нь мөн үр дүнгүй болох нь батлагдсан юм. Иймд алдагдсан орлогыг тогтоохдоо МУ-ын ҮСХ-ны албан ёсны цахим хуудсаас<sup>9</sup> авсан эмэгтэйчүүдийн салбарын дундаж цалинг ашигласан болно.

9 [www.1212.mn](http://www.1212.mn)

### 3.4 ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН АЛДАГДАЛ

Хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал гэдэг нь ажилдаа явж чадахгүй байхаас илүү өргөн ойлголт юм (жишээ нь ажилдаа очихгүй байх). ДХХ-д өртсөний улмаас ажил хийгээгүй, тогтмол ажиллаагүй, үр бүтээмж муутай ажиллах зэрэгт хуримтлагдсан нөлөөллийг үүнд хамруулж үзнэ. Олж буй орлого нь хөдөлмөрийн ахиу бүтээгдэхүүний зөрүүтэй байдал нас, боловсрол, үр чадвар, байршил зэрэг өөрчлөлтийн тусгал байдаг тул хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүд болон хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн хоорондох орлогын зөрүүгээр алдагдлыг тооцож болдог. Судлаачид амьдралынхаа аль нэг үед ДХХ-д өртөж байсан эмэгтэй болон ДХХ-д өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн хоорондох орлогын зөрүүг судлах замаар хүчирхийлээс үүдсэн бүтээмжийн алдагдлыг тооцоолсон болно.

Мэдээллийн хүртээмжгүй байдлаас шалтгаалан (Хязгаарлалтын хэсгийг үзнэ үү) энэхүү судалгаанд өмнө нь Вьетнам Улсад хийсэн амьдралынхаа аль нэг үед ДХХ-д өртөж байсан эмэгтэйчүүд ДХХ-д өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн орлогоос ойролцоогоор 35 хувиар бага цалин авдаг гэсэн өртгийн судалгааны дүнг ашигласан болно (Дуввури, Карни ба Нгуен, 2012). Монголтой соёлын хувьд ойрхон, мөн хоёулаа бага-дунд орлоготой улс орнууд байсан тул Вьетнам Улсын өртгийн судалгааны тооцоог энд ашигласан болно. Судлаачид мөн энэ хоёр бүлгийн эмэгтэйчүүдийн хувьд нэг цагт олгох цалин хөлс ижил төстэй байгааг тайлагнасан болно (Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 2-10 дугаар өсөлтийн график үзүүлэлт, 91-99 дугаар өсөлтийн график үзүүлэлт, 2018). Өөр бусад судалгаануудад мөн эдгээр хоёр бүлгийн хоорондын орлогын ялгааг харуулсан байдаг. Жишээ нь Моррисон ба Орландо (1999) нарын Сантьяго, Манагуа хотод явуулсан судалгаагаар бие махбодын ноцтой хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд өмнө нь хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдээс 43 хувиар бага орлого олдог болохыг тогтоожээ. Үүнтэй ижил Виас (2013) нарын судалгаанд Танзани Улсын бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд өмнө нь хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад 29 хувиар бага орлого олдог гэж дурджээ. Өнөө үед бие махбодын (хүнд) болон/эсвэл бэлгийн хүчирхийллийн хувьд зөрүү нь 43 хувь байна.

Улсын хэмжээнд амьдралдаа хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн тоонд үндэслэн хохирогчдын ажиллаж буй салбарын дундаж цалин хөлстэй харьцуулахад хохирогчид 15, 20, 25 хувиар өндөр орлого олох боломж байсан гэсэн таамгийг дэвшүүлэх замаар мэдрэмжийн шинжилгээг ашиглан хөдөлмөрийн бүтээмжийн алдагдлыг тооцож гаргасан. ДХХ-д өртөгч эмэгтэй нь ажиллаж буй салбарын дундаж цалинтай харьцуулахад 35 хувиар бага орлого олдог гэдгийг нотлоогүй тул хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэй болон хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн орлого хоорондын дундаж зөрүүг тооцоолоход Вьетнам Улс 35 хувийн орлогын өсөлтийг ашиглаагүй болно. Хөдөлмөрийн бүтээмжийн алдагдлыг ДНБ-ний хувиар илэрхийлэн харуулахын тулд хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн орлогын боломжит өсөлтийг улсын хэмжээнд задлан харуулсан болно.

### 3.5 ЖСХ-ИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭР

Зохиогчид эрүүл мэнд, нийгэм, хууль зүйн салбарт үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах хөрөнгө, эх үүсвэрийн тооцоог Дандарын Оюунчимэг, Жигмиддашийн Баярцэцэг нарын (2018) тооцоон дээр үндэслэн гаргасан ба судалгаанд сүүлийн 12 сард хүчирхийлэлд өртсөн хохирогчдын авсан үйлчилгээ бүрийн нэгж үнэ болон 2017 оны үйлчилгээ авсан хүчирхийлэлд өртсөн хохирогчдын тоо гэсэн хоёр гол үзүүлэлтийг ашигласан болно (Оюунчимэг ба Баярцэцэг, 2018).

Гэр бүлийн хүчирхийлэлд 2017 онд өртсөн 2,316 хохирогч 317,165 төгрөг буюу 130.3 ам. долларын өртөг бүхий хамгаалах байр болон 108 тусламжийн төвийн үйлчилгээг авсан байна. Түүнчлэн, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1,612 хүн 31,575 төгрөг буюу 13 ам. долларын нэгж өртөгөөр 1 цэгийн үйлчилгээний төвөөс үйлчилгээ авсан байна.

Д. Оюунчимэг болон Ж. Баярцэцэг (2018) нарын судлаачид хууль зүйн салбарын үйлчилгээ авахад гардаг нэгж өртөг зардлыг судалгаандаа дурдаагүй тул тайланд байгаа мэдээлэл дээр үндэслэн тооцсон (Хүснэгт 2). Цагдаагийн байгууллагын үйлчилгээний зардлыг тооцоходоо хохирогч болон захиргааны хэргийн мэдээллийг ашигласан болно. 2017 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1,120 хохирогчдын 784 нь эмэгтэй хамтрагч буюу эхнэр байсан бөгөөд ДХХ-д өртсөн эмэгтэйчүүд нийт хохирогчдын 70 хувийг (784/1120) эзэлж байгаа юм.

Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн захиргааны зөрчлийн 4,369 хэрэг бүртгэгдсэн бөгөөд цагдаагийн үйлчилгээ авсан 3,058 хохирогчийг ГБХ-ийн гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүдийн хувь хэмжээтэй ижил гэж үзсэн бөгөөд үүнээс олон тооны (784) хохирогчтой хэргийг ГБХ-ийн зөрчилд хамруулан тооцсон.

#### Хүснэгт 2: Үйлчилгээ үзүүлэх нэгж зардал

Боловсон хүчний төрөл	Боловсон хүчний тоо	Цалин (сая төг.)	Захиргааны зардал (сая төг.)	Эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдон гарсан нийт зардал (сая төг.)	Хандсан хүчирхийлэлд өртөгчдийн тоо	Нэгж зардал (сая төг.)	Нэгж зардал (ам. долл.)
Цагдаа	8,774	28,606	2,194 (тус бүр 250,000 төгрөг)	21,560 (Гэр бүлийн нийт хүчирхийллийн 70 хувь)	3,058	7	2,896
Прокурор	585	1,532	291 (тус бүр 4,972.06 төгрөг)	1,823	114	16	6,568

Эх сурвалж: Дандарын Оюунчимэг болон Жигмиддашийн Баярцэцэг (2018) нарын судалгааны ажлыг ашиглан гаргасан зохиогчийн тооцоо

Түүнчлэн ГБХ-ийн хэргийг шийдвэрлэхэд зарцуулсан цаг хугацаа, хэрэг дээр ажиллаж буй албан хаагчдын тоон дээр үндэслэн ГБХ-ийн хэрэг дээр ажиллаж буй 8,744 цагдаагийн ажилтны цалинд жилд ойролцоогоор 28 тэрбум 606 сая төгрөг буюу 11.8 сая доллар зарцуулдаг гэсэн тооцоо гарч байна. Мөн нэг цагдаагийн алба хаагчийн цалингийн бус захиргааны зардалд ойролцоогоор 250,000 төгрөг буюу 102.7 ам. доллар зарцуулдаг бөгөөд нийтдээ 2 тэрбум 194 сая төгрөг буюу 0.9 сая доллар зарцуулдаг байна. Үүний үр дүнд цагдаагийн байгууллагаас нийт 30 тэрбум 800

сая төгрөг буюу 12.7 сая ам. долларын зардал гарч байна. Тайланд гарсан зардлыг хүйсээр нь ангилаагүй байгаа тул эмэгтэйчүүдийн эсрэг ГБХ-ийн улмаас цагдаагийн байгууллагаас гарсан зардлыг тооцохдоо зардлын 70 хувьтай тэнцэх хувь хэмжээгээр тооцсон. Хүчирхийлэлд өртсөн 3,058 эмэгтэйд зарцуулах нийт зардал ойролцоогоор 21 тэрбум 560 сая төгрөг (8.9 сая ам. доллар) буюу нэгж өртөг ойролцоогоор 7 сая төгрөг (2,896 ам. доллар)-тай тэнцэж байна.

2017 онд 114 хэрэг шийдвэрлэх шүүхийн шийдвэр гаргасан бөгөөд ингэхдээ 1 тэрбум 532 сая төгрөг буюу 0.6 сая ам. долларыг цалинд зарцуулсан байна. Түүнчлэн 585 прокурорт захиргааны зардал тус бүрд дунджаар 497,206 төгрөг (204.2 ам. доллар)-ийг зарцуулжээ. 114 хэрэг шийдвэрлэх шүүхийн шийдвэр гаргахад зарцуулсан нийт зардал нь 1 тэрбум 823 сая төгрөг (0.7 сая ам.доллар) буюу нэгж зардал нь ойролцоогоор 16 сая төгрөг (6,568 ам.доллар)-тай тэнцэж байна.

Ихэнх хүчирхийлэлд өртөгсөд олон нийтийн дунд тогтсон хэвшмэл ойлголт, гутаан доромжлолын улмаас эрүүл мэнд, нийгэм, хууль зүйн үйлчилгээ авдаггүй тул үйлчилгээ авсан хохирогчдын хувийг 25, 50, 75 хувиар нэмэгдүүлэх замаар үйлчилгээний ашиглалтыг нэмэгдүүлсэн хувьсагчаар мэдрэмжийн шинжилгээ хийсэн.

### 3.6 ДХХ-ЭЭС ҮҮДСЭН НИЙТ ЗАРДАЛ/ХОХИРОЛ

Энэхүү тайлангийн удиртгал хэсэгт хэлэлцсэний дагуу хүчирхийллийн улмаас гарсан зардал нь идэвхгүй (эс үйлдэл) үйл ажиллагааны зардал болон авсан арга хэмжээний (үйлдэл) зардлаас бүрдэнэ. Ерөнхийдөө гэр бүлийн хүчирхийллийн улмаас Монгол Улсад гарах зардлыг дараах байдлаар тооцоолсон болно. Үүнд:

Хэрэв;

A=Идэвхгүй (эс үйлдэл) байдлын зардал

B=Авсан арга хэмжээний зардал бол

Нийт зардал=A (Хувиасаа гаргасан зардал+Төлбөр төлөгдөөгүй өрхийн үйлдвэрлэл болон асаргаа халамжийн ажлууд+Алдагдсан орлого+Хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал)+B (одоогоор үзүүлж байгаа үйлчилгээний зардал)



## 4. ҮР ДҮН

Сүүлийн 12 сарын хугацаанд хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай байгаа, мөн ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн 36 (36,1 хувь)-аас илүү хувь нь ДХХ-д өртөж байсан гэж мэдэгдсэн бөгөөд сүүлийн 12 сарын хугацаанд хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай байгаа, мөн ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн 13,2 хувь нь бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж мэдэгдсэн байна.

### 4.1 СҮҮЛИЙН 12 САРД ХУВЬ ХҮН ӨӨРӨӨ ГАРГАСАН ЗАРДЛУУД

#### 4.1.1 Эрүүл мэндийн зардлууд

Аргачлалын хэсэгт дурдсан ГССҮТ-өөс үйлчилгээнд зориулж гаргасан зардал болон хувь хэмжээг ЖСХ/ЭЭХ-ын судалгаанд “Сүүлийн 12 сард таны амьдралд таны нөхөр / хамтран амьдрагч тань таньд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах шаардлагатай болтол (тусламж үйлчилгээ аваагүй байж ч болно) хүнд (ямар нэг) гэмтэл учруулж байсан уу?” гэсэн “(805a ба 805b) асуултанд хүчирхийлэлд өртөж байсан талаараа мэдээлэл өгсөн Улсын хэмжээний эмэгтэйчүүдийн хүн амд (11,891) харьцуулан тооцон гаргасан.

Доорх Хүснэгт 3-д сүүлийн 12 сарын хугацаанд хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд хувиасаа гаргасан эрүүл мэндийн зардлын үр дүнг харуулав. Хүчирхийлэлд өрсөн эмэгтэйчүүдийн бараг 66 хувь нь тус бүр нь 17,000 төгрөг (7 ам.долл.)-ийн зардал бүхий зөвлөгөө авах үйлчилгээг дунджаар 4 удаа авсан байна. Хүчирхийлэлд өртсөн цөөн тооны эмэгтэйчүүд (2 хувь) дунджаар 1.7 сая төгрөг (714.2 ам.доллар)-г мэс засал хийлгэхэд зарцуулсан бол 1.8 хувь нь 800,000 төгрөг (328.6 ам.доллар)-ийн нэгж зардлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна. Хувиасаа гаргасан эрүүл мэндийн нийт зардал ойролцоогоор **733 сая төгрөг (301,161.4 ам.доллар)** болж байна.

Хүснэгт 3: Хувь хүн өөрөө гаргасан эрүүл мэндийн зардал

Авсан эрүүл мэндийн үйлчилгээний төрөл	Үйлчилгээ авсан эмэгтэйчүүдийн хувь (N=11,891)	Нэгж зардал (төгрөгөөр)	Эмэгтэйчүүдэд учирсан нийт зардал (сая төг.)	Эмэгтэйчүүдэд учирсан нийт зардал (ам.долл.)
Зөвлөгөө (4 удаа)	65.9%	17,000	133.1	54,678.4
Анхан шатны тусламж	30.4%	4,250	15.3	6,302.3
Мэс ажилбар	2%	1,738,650	413.5	169,845.3
Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх	1.8%	800,000	171.2	70,335.4
			733	301,161.4

Эх сурвалж: Зохиогч

#### 4.1.2 Нийгмийн үйлчилгээний зардлууд

Аргачлалын хэсэгт дурдсаны дагуу 2017 онд хүчирхийлэлд өртсөн 3,228 эмэгтэй нийгмийн үйлчилгээ авсан байна (Оюунчимэг ба Баярцэцэг, 2018). Үүнээс 3,174 эмэгтэйн хүүхэд сургуульд хамрагддаг ба үүний тал буюу 1,587 эмэгтэйн хүүхэд нь хувийн сургуульд хамрагддаг байна. Монгол дахь НҮБХАС-ийн өгсөн нэгж зардлын мэдээлэл дээр үндэслэн зохиогч 1) хүүхэдгүй эсвэл хүүхэд нь улсын сургуульд хамрагддаг хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, болон 2) хүүхэд нь хувийн сургуульд хамрагддаг хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувиасаа гаргасан зардлуудыг тус тусад нь тооцоолсон байна.

Хүүхэдгүй эсвэл хүүхэд нь улсын сургуульд хамрагддаг хүчирхийлэлд өртсөн 2,341 эмэгтэйн хувиасаа гаргасан зардал инфляцын тохируулга хийсний дараа 223,663 төгрөг (91.9 ам.доллар) байна (Хүснэгт 4-г харна уу). Үүнд эрүүл мэндийн даатгал, эм бэлдмэл, унаа, тээврийн, баримт бичиг дахин гаргуулахтай холбоотой торгуулийн төлбөр, баримт бичиг дахин гаргуулах төлбөрийг багтаасан баримтжуулах зардал, нүүх эсвэл гэр барих зардал, ТҮЦ машинаас лавлагаа авах, шилжилт хөдөлгөөн хийлгэх, харилцаа холбоо, эрүүл ахуйн бүтээгдэхүүний зардлууд тус тус багтсан болно. Хүүхэд нь хувийн сургуульд хамрагддаг хүчирхийлэлд өртсөн 1,587 эмэгтэйн хувьд 1.9 сая төгрөг буюу 782.6 ам.долларын зардал гаргасан байна. Тиймээс нийгмийн үйлчилгээнд хамрагдсан хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн нийт зардал ойролцоогоор 3 тэрбум 547.4 сая төгрөг (1.5 сая ам.доллар) болж байна.

Хүснэгт 4: Нийгмийн үйлчилгээний зардлууд

Үйлчилгээ авсан эмэгтэйчүүд	Тоо	Нийт хувиас гарах зардлын дүн (төг.)	Нийт хувиас гарах зардлын дүн (ам.долл.)	Нийт зардал (сая төг.)	Нийт зардал (ам.долл.)
Хүүхэдгүй	754	223,663.4	91.9	168.6	69,272.2
Улсын сургуульд хамрагддаг хүүхэдтэй	1,587	223,663.4	91.9	354.9	145,802.5
Хувийн сургуульд хамрагддаг хүүхэдтэй	1,587	1,905,343.4	782.6	3,023.8	1,242,061.5
Нийт	3,938			3,547.4	1,457,136.2

Эх сурвалж: Зохиолч

#### 4.1.3 Гэр бүл салалтын зардал

Захиргааны бүртгэлээс харахад Монгол Улсад 2017 онд эцэг эх байх эрхтэй 2,767 гэр бүл цуцлуулах шийдвэр болон эцэг эх байх эрхгүй 24 гэр бүл цуцлуулах шийдвэрийг шүүхээр шийдвэрлүүлсэн байна (Оюунчимэг ба Баярцэцэг, 2018). ЖСХ/ЭЭХ-ийн судалгааны тоон мэдээгээр гэр бүлээ цуцлуулсан эмэгтэйчүүдийн 69.8 хувь нь амьдралынхаа аль нэг үед ДХХ-д өртөж байсан байна. ДХХ-ийн улмаас гэр бүлээ цуцлуулсан тухай мэдээлэл дутмаг байгаа тул гэр бүл салалтын 69.8 хувьд тохиолдож байсан ДХХ-ийг гэр бүл салалтын шалтгаан болон хүчин зүйл гэж үзлээ. Аргачлалд тусгагдсан нэгж өртгийг ашиглан, инфляцад тохируулснаар хувь хүнээс гарах гэр бүл салалтын зардал нь эцэг эх байх шийдвэрийг оролцуулаад 1,932 гэр бүл салалтын хэрэг тус бүрт

1.2 сая төгрөг (487.7 ам.доллар) байна. Эцэг эх байх шийдвэрийг оролцуулаагүй 17 хэргийн тухайд гэр бүл салгуулахад хувиасаа гаргах зардал нь инфляцын тохируулга хийгдсэний дараах байдлаар ойролцоогоор 1 сая төгрөг (445.3 ам.доллар) байна. Шүүхээр шийдвэрлүүлсэн гэр бүл цуцлуулах 1,949 хэргийн нийт зардал нь ойролцоогоор 2 тэрбум 312.3 сая төгрөг (949,813.9 ам.доллар) гэж тооцож байна.

## 4.2 ТӨЛБӨР ТӨЛӨГДӨӨГҮЙ ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОЛОН АСАРГАА ХАЛАМЖИЙН АЖЛУУД

Аргачлалын хэсэгт дурдсаны дагуу тооцоолол хийхийн тулд энэхүү судалгаанд Гана Улсын өртгийн судалгаа (Асанте нар, 2019)-ны өгөгдлийг ашигласан. Сүүлийн 12 сарын хугацаанд манай улсад ДХХ-ийн аль нэг хэлбэрт (бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, хянах зан үйл, эдийн засгийн хүчирхийлэл)-д өртсөн гэж мэдэгдсэн эмэгтэйчүүдийн түвшин 35 хувь (328,079) байна. Гана Улсын ДХХ-ийн улмаас хийх шаардлагатай болсон асран халамжлах ажлын хувь хэмжээг ашиглан тооцоход Монгол Улсын 49,212 эмэгтэй дунджаар 9-33 өдрийг цалин хөлсгүй өрхийн үйлдвэрлэл болон асаргаа халамжийн ажилд зарцуулж байдаг бөгөөд нийт хугацаа нь 442,908 - 1,623,996 өдөр хүртэл байна. Цалин хөлсгүй өрхийн үйлдвэрлэл болон асаргаа халамжийн ажил хийсний улмаас ажил хөдөлмөр эрхлээгүй хоногийг Монгол Улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 10,910 төгрөг<sup>10</sup> (240,000 төг / 22 хоног) буюу 4.5 ам.доллараар үржүүлбэл нийт мөнгөн алдагдлын хэмжээ нь 12 сарын хугацаанд **4 тэрбум 832 сая төгрөг (2 сая ам.доллар)-с 17 тэрбум 718 сая төгрөг (7.3 сая ам.доллар)** болж байна.

Хүснэгт 5-д 95%-ийн итгэлцлийн интервал дээр үндэслэн цалин хөлсгүй өрхийн үйлдвэрлэл болон асаргаа халамжийн ажил хийж алдсан дундаж ажлын хоног болон алдсан хоногийн дээд болон доод хязгаарыг харуулсан болно.

Хүснэгт 5: Эмэгтэйчүүдийн асаргаа халамжийн ажил хийж алдсан ажлын хоногуудын тоо

	Алдсан хоногийн дундаж тоо (N=49,212)	Алдсан хоногийн нийт тоо	Нийт мөнгөн алдагдал (сая төг.)	Нийт мөнгөн алдагдал (сая ам.долл.)
Доод хязгаар	9	442,908	4,832	2.0
Дундаж утга	21	1,033,452	11,275	4.6
Дээд хязгаар	33	1,623,996	17,718	7.3

Эх сурвалж: Зохиогч

## 4.3 АЛДАГДСАН ОРЛОГО

Аргачлалын хэсэгт дурдсанчлан, салбар бүрийн эмэгтэйчүүдийн дундаж цалин хөлсийг ашиглан алдагдсан орлогыг улсын хэмжээнд тооцон гаргав. ДХХ-ийн улмаас өмнө нь хамтрагчтай байсан

10 2017 онд Монгол Улсын Хөдөлмөрийн хөлсний сарын доод хэмжээ 240,000 Төгрөг байсан. Тиймээс өдрийн хөдөлмөрийн хөлсний хамгийн бага хэмжээ нь 10,910 Төгрөг (240,000/22).

эсвэл одоо хамтрагчтай байгаа, ажил хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн тав (5.31 хувь)-аас илүү хувь нь 12 сарын хугацаанд дунджаар 19 хоног ажил хөдөлмөр эрхэлж чадаагүй байна. Алдагдсан орлогыг тооцоолохдоо эмэгтэй тус бүрийн ажилладаг тухайн салбарын дундаж цалин хөлсийг тухайн эмэгтэй хөдөлмөр эрхэлж чадаагүй гэж мэдэгдсэн ажлын хоногуудаар үржүүлсэн болно.

Энэ тооцооллыг улсын хэмжээнд авч үзвэл сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийллийн улмаас 26,611 Монгол эмэгтэйн алдагдсан орлого дунджаар 695,855.2 төгрөг (285.8 ам.доллар) байгаа бөгөөд дунджаар нийт дүн нь 18 тэрбум 517 сая төгрөг (7.6 сая ам.доллар) болж байна.

Хүснэгт 6-д 95%-ийн итгэлцлийн интервал дээр үндэслэн алдагдсан орлогын дээд болон доод хязгаарыг харуулсан болно.

*Хүснэгт 6: Сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүдийн алдагдсан орлого*

	Алдсан хоногийн дундаж тоо (N=187)	Алдсан хоногийн нийт тоо (N=26611)	Дундаж алдагдсан орлого (төг.)	Нийт алдагдсан орлого (сая төг.)	Нийт алдагдсан орлого (сая ам.долл.)
Доод хязгаар	13.9	370,691	442,658.8	11,780	4.8
Дундаж утга	18.8	500,021	695,855.2	18,517	7.6
Дээд хязгаар	23.6	629,084	949,051.7	25,255	10.4

*Эх сурвалж: Зохиогч*

#### 4.4 ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН АЛДАГДАЛ

Аргачлалын хэсэгт хэлэлцсэн өртөг, зардал тооцох судалгааны ажлын дагуу хоёр бүлгийн эмэгтэйчүүдийн цалин хоорондын орлогын зөрүүг судлах замаар ДХХ-ийн улмаас алдсан хөдөлмөрийн бүтээмжийг тооцоолсон. Вьетнам Улсад хийсэн судалгаагаар ДХХ-д өртөж буй эмэгтэйчүүд ДХХ-д өртөж байгаагүй эмэгтэйчүүдээс 35 хувиар бага цалин авдаг болох нь тогтоогдсон байна (Дуввур нар, 2012). Энэхүү судалгаанд үндэслэн Монгол улсын хувьд ч ДХХ-д өртсөн эмэгтэйчүүд ДХХ-д өртөөгүй эмэгтэйчүүдээс бага орлого олдог гэж үзэж байна. Монголд амьдралынхаа аль нэг үед ДХХ-д өртөж байсан, өмнө нь хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай байгаа, ажил хөдөлмөр эрхэлдэг 294,729 эмэгтэй байна. (Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, хянах зан үйл, эдийн засгийн хүчирхийлэл) (Хүснэгт 7-г харна уу).

ДХХ-д өртсөн эмэгтэйчүүдийн орлогыг ДХХ-д өртөөгүй үед тухайн салбарын дундаж цалингаас 15-аас 25 хувиар өндөр байхаар тооцож ДХХ-д өртөгсдийн боломжит орлогын алдагдалд мэдрэмжийн шинжилгээ явуулсан. ДХХ-д өртөж буй хүмүүсийн орлогын зөрүүтэй байдлаас үүдэн эдийн засагт хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал учирч байна. Хэрэв хүчирхийлэлд өртөгсдийн орлогыг 15 хувиар өндөр гэж үзвэл орлогын дундаж алдагдал ойролцоогоор 1.3 сая төгрөг буюу 565.1 ам.доллар болж байна.

Орлогын боломжит өсөлт нь гэр бүл болон засгийн газрын хүрээнд тогтоогдоогүй, эмэгтэйчүүдэд тохиолддог хүчирхийллийн улмаас бидэнд мэдэгдэхгүй байгаа хөдөлмөрийн бүтээмжийн алдагдлыг илэрхийлнэ.

Боломжит орлогыг 15 хувиар нэмэгдүүлж үзвэл 2017 оны Улсын хэмжээний алдагдлын тооцоо нь 405.4 тэрбум төгрөг (166.6 сая ам.доллар)-т хүрч байна. Боломжит орлогыг 25 хувиар нэмэгдүүлбэл энэхүү алдагдлын дүн 675.8 тэрбум төгрөг (277.6 сая ам.доллар) болж нэмэгдэж байгаа юм. Хэрэв энэхүү хөдөлмөрийн бүтээмжийн алдагдлыг ДНБ-ий хувь хэмжээгээр авч үзвэл алдагдлын хэмжээ нь 2017 оны ДНБ-ий 1.5-2.4 хувьтай тэнцэж байгаа нь хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал ямар чухал асуудал болохыг харуулж байна.

#### Хүснэгт 7: Хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал

Амьдралдаа хүчирхийлэлд өртөж байсан хөдөлмөр эрхэлэгчдийн тоо	Орлогын өсөлтийн тооцоот хувь	Дундаж орлогын алдагдал (төг.)	Дундаж орлогын алдагдал (ам.долл.)	Нийт алдагдал (сая төг.)	Нийт алдагдал (сая ам.долл.)	2017 оны ДНБ (тэрбум төг.)	2017 оны ДНБ (тэрбум ам.долл.)	2017 оны ДНБ-ий хувь хэмжээ
294,729	15%	1,375,794	565.1	405,486	166.6	27,876.3	11.5	1.45%
294,729	20%	1,834,392	753.5	540,649	222.1	27,876.3	11.5	1.94%
294,729	25%	2,292,990	941.9	675,811	277.6	27,876.3	11.5	2.42%

Эх сурвалж: Зохиогч

### 4.5 ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР

Хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээнд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг тооцохдоо хүчирхийлэлд өртөгчийн авч буй эрүүл мэнд болон нийгмийн үйлчилгээний нэгж зардал болон эдгээр үйлчилгээг авч буй хүмүүсийн тоон дээр суурилна (Оюунчимэг ба Баярцэцэг, 2018). Хууль зүйн салбарын хувьд аргачлалын хэсэгт дэлгэрэнгүй дурдсанаар бүртгэгдсэн ГБХ-ийн хохирогчийн тоо болон захиргааны хэргүүд дээр үндэслэн нэгж зардлыг тооцоолсон. Д.Оюунчимэг, Ж.Баярцэцэг нарын гаргасан тайлангийн цалин, хөлс болон захиргааны зардлыг мөн ашигласан болно.

Шаардлагатай үйлчилгээ авч буй хүчирхийлэлд өртөгчдийн тоо тус бүр 25, 50, 75 хувиар өсөхөд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр болон ДХХ-ийг шийдвэрлэхэд зарцуулагдаж буй зардлын мөнгөн дүнг доорх хүснэгт 8-д үзүүлэв. Одоогийн үйлчилгээг авч буй хүчирхийлэлд өртөгсдийн тооны өсөлтөөс хамаарч төрөл бүрийн үйлчилгээ авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэр нь 30 тэрбум төгрөг (12.4 сая ам.доллар)-өөс 42.3 тэрбум төгрөг (17.4 сая ам.доллар)-т хэлбэлзэж байна. Жишээ нь: одоогийн үйлчилгээ авч буй хэрэглэгчдийн тоог 50 хувиар нэмэгдүүлбэл нийт шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр нь 36.3 тэрбум төгрөг (14.9 сая ам.доллар) болж нэмэгдэх юм.

Үйлчилгээ авч буй эмэгтэйчүүдийн тоог 75 хувиар нэмэгдүүлэхэд бодитоор үйлчилгээ авч буй бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж буй хохирогчдын хувь хэмжээ нь нийт хохирогчдын

зөвхөн 10.5 хувьд очиж байгаа гэдгийг анхаарах нь чухал юм (2017 оны ЖСХ-ийн судалгаа судалгааны дагуу 118,804).

#### Хүснэгт 8: Хөрөнгө эх үүсвэрийн шаардлагууд

Үйлчилгээний төрөл	Хүчирхийлэлд өртөгчдийн тоо	Нэгж зардал (төг.)	Нэгж зардал (ам.долл.)	Нийт зардал (сая төг.)	Нийт зардлын 25% (сая төг.)	Нийт зардлын 50% (сая төг.)	Нийт зардлын 75% (сая төг.)
Хамгаалах байр болон 108 тусламжийн төв	2,316	317,165	130	735	918	1,102	1,285
НЦҮТ	1,612	31,575	13	51	64	76	89
Цагдаа	3,058	7,050,236	2,896	21,560	26,950	32,339	37,729
Шүүх	114	15,989,872	6,568	1,823	2,279	2,734	3,190
				24.2 тэрбум төг (9.9 сая ам.долл.)	30.2 тэрбум төг (12.4 сая ам.долл.)	36.3 тэрбум төг (14.9 сая ам.долл.)	42.3 тэрбум төг (17.4 сая ам.долл.)

Эх сурвалж: Зохиогч

#### 4.6 НИЙТ ЗАРДАЛ БА ЗАРДЛЫН БҮЛЭГЛЭЛ

Нийт зардлын тооцооны үр дүн нь хувь хүн өөрөө гаргасан зардал, төлбөр төлөгдөөгүй өрхийн үйлдвэрлэл болон асаргаа халамжийн зардал, алдагдсан орлого, хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал, засгийн газар болон донор байгууллагад учирч буй үйлчилгээний зардлуудаас бүрдэнэ. Ихэнхдээ тодорхой бодит зардал гэж үздэггүй хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал нь Монгол Улсад учирч байгаа ДХХ-ийн нийт зардлын 90 хувийг эзэлж байна (Хүснэгт 9-ийг үзнэ үү). Хамгийн гол нь засгийн газар болон хандивлагч байгууллагын бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүмүүст үзүүлж буй үйлчилгээ нь Монгол Улсын эдийн засагт учирч буй нийт алдагдлын 4 хувьтай тэнцэж байгаа явдал юм. Энэ нь тодорхой бус нөхцөлд идэвхгүй (эс үйлдэл) үйл ажиллагааны зардал (хувиасаа гаргасан зардал, төлбөр төлөгдөөгүй өрхийн үйлдвэрлэл болон асаргаа халамжийн зардал, алдагдсан орлого, хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал зэргийг багтаасан 577 тэрбум төгрөг буюу 237 сая ам.доллар) нь өнөөгийн үйлчилгээний зардлын түвшинээс бараг 24 дахин их байгааг онцлон харуулж байна. Одоогийн авч буй хариу арга хэмжээ нь цогц байдлаар асуудлын цар хүрээг бүрэн хамарч чадахгүй байгаа нь Засгийн газарт өгөх тодорхой сануулга болж байна. Монгол Улс ГБХ-ийн асуудлыг зохих ёсоор авч үзэхгүй ГБХ-ийн хувь хэмжээ энэ байдлаар үргэлжилбэл цаашид эдийн засаг, эрүүл мэнд, нийгмийн сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлөх болно.

Хүснэгт 9: Улсын хэмжээний тооцоо

Зардлын ангилал	Нийт зардал (сая төг.)	Нийт зардал (сая ам.долл.)	Нийт зардлын хувь хэмжээ	ДНБ-д эзлэх хувь
Хувиасаа гаргасан зардал	6,592.8	2.7	1.1	0.02
Алдагдсан орлого	18,517.4	7.6	3.1	0.1
Төлбөр төлөгдөөгүй өрхийн үйлдвэрлэлийн болон асаргаа халамжийн ажлууд	11,275	4.6	1.9	0.04
Хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал	540,648.6	222.1	89.9	1.9
Идэвхгүй (эс үйлдэл) үйл ажиллагааны зардал	577,033.8	237	96	2.1
Үзүүлж буй үйлчилгээний зардал (Засгийн газар болон донор байгууллага)	24,167.9	9.9	4	0.1
Нийт	601,201.7	247		2.2

Эх сурвалж: Зохиогч

## 5. ХЯЗГААРЛАЛТУУД

Алдагдсан орлого болон хувиасаа гаргасан зардлыг тооцохдоо зөвхөн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийг хамруулан дутуу тооцоо хийгдсэн. Түүнчлэн шаардлагатай мэдээллүүд байхгүй тул хуулийн үйлчилгээний зардал болон үл хөдлөх хөрөнгөө солих зэрэгт хувиасаа гаргасан зардлын элементүүдийг энэхүү тооцоонд оруулаагүй.

Мэдээллийн зөрүү болон мэдээлэл байхгүйн улмаас төрөл бүрийн тооцоо хийхэд томоохон бэрхшээлүүд тулгарч байсныг тэмдэглэх нь зүйтэй. 2017 онд хийсэн ЖСХ/ЭЭХ-ийн судалгаа нь хүчирхийллийн эдийн засгийн зардлыг тодорхойлоход чиглэгдээгүй тул байгаа хоёрдогч эх үүсвэр дээр тулгуурлан бодитоор бүх тооцооллыг хийж таамаг дэвшүүлсэн болно. Жишээ нь: ЖСХ/ЭЭХ-ийн судалгаагаар сүүлийн 12 сарын хугацааг авч үзэхээс илүүтэйгээр нийгмийн үйлчилгээ авах, эмэгтэйчүүд амьдралынхаа аль нэг үед алдсан ажил эрхлэлт зэрэг чиглэлээр тоон мэдээлэл цуглуулсан. Инфляцаас шалтгаалан жил өнгөрөх тусам улсын валютын ханш өөрчлөгдөх болон зэргээс үүдэн амьдралын аль нэг үед хүчирхийлэлд өртсөний улмаас гарсан зардалд үндэслэн зардлыг тооцох нь учир дутагдалтай юм. Мөн Монгол Улсад явуулсан ЖСХ/ЭЭХ-ийн судалгаанд хүчирхийлэлд өртөгчдийн цалин хөлс болон асаргаа халамжийн ажлын мэдээллийг цуглуулаагүй байна.

Хөдөлмөрийн бүтээмжийн алдагдлыг тооцоолохдоо зохиолчид Вьетнам Улсын өртөг зардлын судалгаа (Дуввүри нар, 2012)-ны нэгэн адил ДХХ-д өртөж буй эмэгтэйчүүд болон ДХХ-д өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн орлогын зөрүүг тооцоохын тулд хоёр үе шаттай инструменталь хувьсах регрессийг ашиглахаар төлөвлөсөн. Энэхүү судалгааны арга нь цалин хөлс болон хүчирхийллийн хоорондын эндоген чанарыг багасгах эдийн засгийн стандарт арга юм. Хүчирхийлэл цалин хөлсөнд нөлөөлөх байдлын тухайд эндоген чанар нь эдийн засгийн шинжилгээний үеэр тулгардаг нийтлэг асуудал боловч цалин нь өөрөө хүчирхийлэл бий болох шалтгаан байж мөн болдог. Цалингийн зөрүүнээс шалтгаалсан улсын орлогын алдагдлын тооцоог хийхийн тулд регрессийн коэффициентыг шилжүүлж тооцсон. Вьетнам Улсад хийсэн тооцооллын хамгийн тохиромжтой төлөөлөх хувьсагчаар гэр бүлийн хосууд хоорондын хэрүүл маргааны давтамжийг тодорхойлсон.

Монголд хийсэн ЖСХ/ЭЭХ-ийн судалгаа нь амьдралдаа ДХХ-д өртөж байсан эсэх (анхны бие даасан хувьсагч), хэрүүл маргааны давтамж (төлөөлөх хувьсагч), байршил, өөрийн мэдээлснээр эрүүл мэндийн байдал, нас, боловсрол, эд хөрөнгө зэрэг ковариат бүхий регрессийн үндсэн хувьсагчуудтай байсан. Харин өмнө дурдсанчлан, ЖСХ/ЭЭХ-ийн судалгаанд “Орлого” гэсэн гол бие даасан хувьсагчийн өгөгдөл байгаагүй бөгөөд мөн хөдөлмөрийн хүчний судалгааны мэдээллээс энэхүү мэдээллийг авах боломжгүй байв. Эсрэгээрээ алдагдсан орлогыг тооцоолоход зөвхөн салбарын дундаж цалин хөлсийг тооцох боломжгүй бөгөөд нас, байршил, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал, мэргэжил, ажиллаж буй салбарын цалин хөлсний мэдээллийг харгалзан үзэх шаардлагатай болсон.

Цаашид эдгээр зардлыг тооцоолохын тулд Монгол Улсад охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эдийн засгийн зардалд чиглэсэн анхан шатны судалгааг улсын хэмжээнд хийх шаардлагатай байна.



## 6. ГОЛ ЗӨВЛӨМЖҮҮД

Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх “Тогтвортой Хөгжил 2030” зорилтыг хангахын тулд “нэг засгийн газар” болон “нэг нийгэм”-д нөлөөлөхүйц цогц, уялдаатай бодлого шаардлагатай байгаа талаар дурдсан бөгөөд эдгээр зорилгод чиглэсэн Монгол Улсын хөгжил дэвшлийн сүүлийн үеийн үндэсний үзэл санааны хувьд өнөөгийн ядуурал нь цаашдын хөгжил дэвшилд саад тотгор учруулж байгаа учир эдийн засгийн өсөлтийн зогсонги байдлыг үүнд онцлон авч үзсэн байна (Монгол Улсын Засгийн газар, 2019 он). Түүнчлэн жөндөрийн эрх тэгш байдлыг хангах хууль, эрхзүйн орчин хангалтгүй байгаа нь охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг шийдвэрлэхэд саад учруулж байна (Монгол Улсын Засгийн газар, 2019 он).

Энэ тал дээр охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх найдвартай үнэн зөв тоон мэдээлэл зайлшгүй шаардлагатай байгаа юм. 2017 оны ЖСХ/ЭЭХ-ийн судалгаанд Монгол Улсад охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголт/ мэдлэг хомс байгаа талаар дурдсан байна. Энэхүү судалгааны үр дүнд хувь хүн өөрөө гаргасан зардлаас эхлэн хөдөлмөрийн бүтээмжээ алдсан зардлууд хүртэлх ДХХ-ийн эдийн засгийн өртгийн хүрээг бий болгосон мэдээллийн санг өргөжүүлсэн болно.

Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил, нийгмийн эрүүл мэндийн асуудал байхын зэрэгцээ хувь хүн, олон нийт төдийгүй цаашлаад өргөн хүрээнд нийгмийн амьдралд, улс орны эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг. Судалгааны үр дүн ДХХ-д өртсөн хүмүүс хувиасаа ихээхэн хэмжээний зардлуудыг гаргадаг болохыг харуулж байна. Асаргаа халамжийн ажил болон алдагдсан орлого гэх мэт хохирлууд учирдаг бөгөөд хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал нь Монгол Улсад ДХХ-ийн нийт зардлын 85 хувийг эзэлж байна. Хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал нь зөвхөн эмэгтэйчүүд болон тэдний гэр бүлд нөлөөлөөд зогсохгүй улс орны эдийн засгийн өсөлтөд мөн саад учруулдаг байна. Ялангуяа ядуурлын асуудлыг шийдвэрлэх, тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, охидод нэн шаардлагатай үйлчилгээг хэрэгжүүлэхийг зорьж буй улс орны хувьд энэ нь ноцтой асуудал болж байна (НҮБ-ын Эмэгтэйчүүд, НҮБ-ын Хүн амын сан, ДЭМБ, 2015). Улс орнууд энэхүү томоохон хөрөнгө оруулалт шаарддаг, маш чухал ач холбогдолтой үйлчилгээнүүдийг бий болгох, хүргэх чиглэлд өөрийн улсын онцлогт тохирсон төлөвлөгөөг боловсруулж ажилладаг.

Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эдийн засагт учруулах зардлыг тооцох нь засгийн газрын шийдвэр гаргагчдад Монгол Улсын эдийн засгийн нөөц боломжид учирч болох системийн алдагдлыг тодорхой харуулах боломжийг олгох утгаараа чухал ач холбогдолтой юм. Идэвхгүй (эс үйлдэл) үйл ажиллагааны зардлын тооцоог гаргаснаар охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг цогц байдлаар бүхэлд нь шийдвэрлэхэд идэвхтэй хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байгааг энэхүү судалгаа тодорхой харуулж байна. Эдийн засгийн төлөвлөлтийн хүрээнд системийн алдагдлын тооцоо нь охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу

арга хэмжээ авахад чиглэсэн бодлого, хөтөлбөрт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр гарах үр ашгийн талаарх суурь ойлголтыг өгөх юм. Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн зардлын тооцоо нь асуудлын хүрээг илүү сайн ойлгох боломжийг олгож байгаагаас гадна төсвийн хуваарилалтын талаар илүү сайн мэдээлэл өгөх мэдлэгийн суурийг бий болгож байгаа ба “Тогтвортой хөгжлийн зорилт”-д хүрэх Монгол Улсын зорьж буй “нэг засгийн газар”, “нэг нийгэм” арга замыг илүү ойлгоход тусалж байна.

### **Судалгааны гол үр дүнг доор харуулав. Үүнд:**

- Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Монгол Улсын эдийн засаг, нийгэмд эдийн засгийн томоохон үр дагаврыг авчирч байна.
- Нийт зардлыг 601.2 тэрбум төгрөг (247 сая ам.доллар) гэж тооцсон ( Доорх Зураг 1-ийг үзнэ үү)
  - Авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нийт зардал (үйлчилгээний үрсгал зардал) нь 24 тэрбум 167.9 сая төгрөг (9.9 сая ам.доллар) болж байна
  - Эс үйлдлийн нийт зардал нь 577 тэрбум төгрөг (237 сая ам.доллар) бөгөөд үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдаж байгаа зардлын өнөөгийн түвшинээс бараг 24 дахин их мөнгөн дүнтэй тэнцүү юм.
  - Үл үзэгдэх зардал гэж ихэнхи тохиолдолд тооцогддог хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал нь Монгол Улсад учирч байгаа ДХХ-ийн нийт хохирлын 90 хувийг эзэлж байна.
  - Хүчирхийлэлд өртөж байгаа хүмүүсийн алдагдсан орлогын дүн нь 18 тэрбум 517.4 сая төгрөг (7.6 сая ам.доллар) болж байна.
  - Төлбөргүй хөдөлмөр болох өрхийн үйлдвэрлэл болон асаргаа халамжийн ажлын нийт дүн нь 11 тэрбум 275 сая төгрөг (4.6 сая ам.доллар) болж байна.
  - Хувь хүн өөрөө гаргасан зардлын дүн нь 6 тэрбум 592.8 сая төгрөг (2.7 сая ам.доллар) болж байна.
- Шаардлагатай нөөц: одоо үйлчлүүлж байгаа хэрэглэгчдийн тоог 75 хувиар өсгөхөд шаардлагатай хөрөнгийн хэмжээ нь идэвхигүй байдал (эс үйлдэл)-ийн зардлын дөнгөж 7.3 хувьтай тэнцэх хэмжээгээр л нэмэгдэнэ. Энэ нь хөрөнгө нөөцөд ачаалал учруулахгүйгээр ДХХ-д өртөж байгаа хохирогчдод үйлчилгээгээ өргөжүүлэн хүргэх боломжтойг харуулж байна.

### **Энэхүү судалгааны гол үр дүнд үндэслэн дараахь гол зөвлөмжийг боловсруулав. Үүнд:**

- ДХХ-ийн түвшин өндөр байгаа болон түүнтэй холбоотой улсад учирч буй эдийн засгийн зардлыг бууруулахын тулд урьдчилан сэргийлэх ажилд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.
- Хүчирхийлэлд өртсөн хүмүүст үзүүлдэг эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх.
- Гэмт хэрэгтэнд үзүүлэх хариуцлагын тогтолцоог үр дүнтэй болгох, хохирогчид үзүүлэх

хамгаалалын үйлчилгээг үр дүнтэй болгохын тулд цагдаа, шүүхийн салбарыг бэхжүүлэхэд илүү хөрөнгө санхүүжилтийг зориулах.

- Хүчирхийллийн үр дагавар, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд үзүүлэх нөлөөллийг бууруулах, амьдралаа хэвийн байдлаар үргэлжлүүлэхэд шаардлагатай үйлчилгээг үзүүлэхийн тулд НЦҮТ, хамгаалах байруудад болон ДХХ-ийн хохирогчдод мөнгөн дэмжлэг үзүүлэх.
- Монгол Улсын Засгийн газраас хүчирхийллийн эсрэг үйлчилгээнд зарцуулж буй одоогийн санхүүжилтээ 5 дахин нэмэгдүүлэх буюу хамгийн багадаа жилийн төсвийн 1 хувийг хүчирхийлэлтэй тэмцэх ажилд зарцуулдаг байх.
- Засгийн газар Улс орны эдийн засгийн өсөлт, хүн амын сайн сайхан байдалд чиглэсэн эдийн засаг, нийгмийн бодлогод ДХХ-ийн нөлөөллийн дүн шинжилгээ хийх асуудлыг зайлшгүй тусгадаг байх.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь ДХХ-д өртсөн ажилчдад тусгай цалинтай чөлөө олгох нөхцөл бүхий ДХХ-ийн эсрэг ажлын байрны цогц бодлогыг бий болгоход хувийн хэвшлийн байгууллагуудыг татан оролцуулах.
- НҮБ-ын Хүн амын сан болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хувийн хэвшлийн байгууллагуудын ЖСХ болон ДХХ-ийн өртгийн судалгааг хийх асуудлыг авч үзэх (Асанте нар, 2019; Вара Хорна, 2013, 2015 судалгааг харна уу).
- ТХЗ-д хүрэх болон ОЭЭХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд ОЭЭХ, ядуурал болон эдийн засгийн өсөлт хоорондын нягт хамаарлын талаар илүү гүнзгий ойлголтыг бий болгох чиглэлээр ажиллах.

Асанте, Ф., Фенни, А., Дзидзор, М., Чадха, М., Скрайвер, С., Баллантин, С., ба Дувури, Н (2019). Гана дахь охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн нийгэм, эдийн засгийн зардал: Улсын техникийн тайлан. <https://www.whatworks.co.za/documents/publications/302-10079-ghana-technical-report-final-web-file/file> холбоосноос харна уу.

Дандарын Оюунчимэг, ба Жигмиддашийн Баярцэцэг (2018). Жендэрт суурилсан хүчирхийллийн зардлын судалгааны 1-р хэсэг: Монгол Улс дахь үйлчилгээний зардал.

Дувури, Н., Карни, П., ба Нгуен, Х.М (2012). Вьетнам Улс дахь эмэгтэйчүүдийн гэр бүлийн хүчирхийллийн зардлыг тооцоолох судалгаа: НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын Вьетнам дахь оффис. <https://www.unwomen.org/en/digital-library/publications/2013/2/estimating-the-cost-of-domestic-violence-against-women-in-viet-nam> холбоосноос харна уу.

Дувури, Н., Скрайвер, С., Форде, С., Чадха, М., Рагхавендра, С., О'Бриен, Л., ... Баллантин, С (2019). Бага, дунд орлоготой охид, эмэгтэйчүүд эсрэг хүчирхийллийн нийгэм, эдийн засгийн зардлыг тооцох аргачлалын талаархи удирдамж. <https://www.whatworks.co.za/documents/publications/348-methodological-guidance-final/file> холбоосноос харна уу

Феорон, Ж., ба Хоэффлер, А (2014). 2015 оноос хойшхи хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан зөрчил маргаан, хүчирхийллийн зардал, үр ашиг. Зөрчил маргаан, хүчирхийллийн үнэлгээний баримт бичиг, Копенгагены зөвшилцлийн төв

Монгол Улсын Засгийн газар (2019 он). Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл 2019: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт. Улаанбаатар: Монгол Улсын Засгийн газар.

Нийгмийн ерөнхий судалгаа (2009). Гана Улсын цаг ашиглалтын судалгаа.

Олон Улсын хөдөлмөрийн байгууллага (2018). Олон Улсын цалин хөлсний тайлан 2018/19: Жендэрийн цалин хөлсний зөрүүний ард юу байгаа вэ?. Женев: ОУХБ. [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---dcomm/---publ/documents/publication/wcms\\_650553.pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---dcomm/---publ/documents/publication/wcms_650553.pdf) холбоосноос харна уу.

Моррисон, А. Р., ба Орландо, М. Б (1999). Гэр бүлийн хүчирхийллийн нийгэм, эдийн засгийн зардал: Чили, Никарагуа. Гэрт хэт ойр байх: Америк дахь гэр бүлийн хүчирхийлэл, 51-80.

МУҮСХ (2015). Монгол Улсын цаг ашиглалтын судалгаа.

МУҮСХ ба НҮБХАС (2018 он). Монгол Улсын жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа: Хүчирхийллийн нүцгэн үнэн.

МУҮСХ (2018). Монгол Улсын хүн амын тоо, насны бүлэг хүйсээр .

[http://www.1212.mn/Хүснэгт.aspx?tbl\\_id=DT\\_MYUCX\\_0300\\_003V16aSEX\\_select\\_all=16aSEXSingleSelect=6aAGE\\_GROUP5\\_select\\_all=06aAGE\\_GROUP5SingleSelect=\\_16aYear\\_select\\_all=06aYearSingleSelect=6aviewtype=Хүснэгт-холбоосноос](http://www.1212.mn/Хүснэгт.aspx?tbl_id=DT_MYUCX_0300_003V16aSEX_select_all=16aSEXSingleSelect=6aAGE_GROUP5_select_all=06aAGE_GROUP5SingleSelect=_16aYear_select_all=06aYearSingleSelect=6aviewtype=Хүснэгт-холбоосноос) харна уу

МУУСХ (2020a). Монгол Улсын хүн амын тоо.: <https://www.en.MYUCX.nm> холбоосноос харна уу

МУУСХ (2020b). Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал. Улаанбаатар: Үндэсний статистикийн газар.

Рагавендра, С., Чадха, М., ба Дувури, Н. (2018). Андра Прадеш дахь дотно харилцагчийн хүчирхийллийг бууруулах зорилгоор санал болгож буй арга хэмжээний зардал, үр ашгийн шинжилгээ. [https://www.copenhagenconsensus.com/sites/default/files/ap\\_crime\\_and\\_violence\\_formatted.pdf](https://www.copenhagenconsensus.com/sites/default/files/ap_crime_and_violence_formatted.pdf).- холбоосноос харна уу

Скрайвер, С., Дувури, Н., Аше, С., Рагавендра, С. ба О'Доновон, Д (2015). 'Хүчирхийллийн талаарх үзэл баримтлал: Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг ойлгоход цогц арга. Ажлын баримт №. 1: Ирландын Үндэсний Их Сургууль, Голуэй. <https://www.whatworks.co.za/documents/publications/22-conceptualising-violence-a-holistic-approach-to-understanding-violence-against-women-and-girls/file-> холбоосноос үзнэ үү.

НҮБ-ын эмэгтэйчүүдийн байгууллага, НҮБХАС, ДЭМБ, НҮБХХ, НҮБХХ (2015). Хүчирхийлэлд өртсөн эмэгтэй, охидод шаардлагатай үйлчилгээний багц: Гол элементүүд, чанарын удирдамж. Нью Йорк: НҮБ-ын эмэгтэйчүүдийн байгууллагын төв байр. <https://www.unwomen.org/en/digital-library/publications/2015/12/essential-services-package-for-women-and-girls-subject-to-violence>-холбоосноос үзнэ үү.

ЮНЕСКО (2007). Гэр бүлийн хүчирхийллийн нийгэм, эдийн засгийн зардал. Улаанбаатар: ЮНЕСКО.

Вара Хорна, А. (2013). Перу дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба санхүүгийн үр дагавар. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх төсөл, Олон Улсын Герман хамтын ажиллагааны GIZ байгууллага ба Сан Мартин де Порресийн их сургууль, Лима. <https://www.genderingermandevelopment.net/>-холбоосноос үзнэ үү.

Вара Хорна, А (2015). Болив хотын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба түүний бизнес дэхь санхүүгийн үр дагавар. эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх төсөл, Олон Улсын Герман хамтын ажиллагааны GIZ байгууллага ба Сан Мартин де Порресийн их сургууль, Лима. [https://www.giz.de/en/downloads/ComVoMujer\\_Executive\\_Summary\\_ViolenceagainstwomenanditsfinancialconsequencesforbusinessesinBolivia\\_BO\\_2015.pdf](https://www.giz.de/en/downloads/ComVoMujer_Executive_Summary_ViolenceagainstwomenanditsfinancialconsequencesforbusinessesinBolivia_BO_2015.pdf)-холбоосноос үзнэ үү.

Виас, С (2013). 2008-2009 оны эмэгтэйчүүдийн орлого ба хамтрагчийн хүчирхийлэл хоорондын холбоог тооцоолон судлах: Танзани Улсын үндэсний судалгааны тайлан. <http://documents.worldbank.org/curated/en/505151468313196254/Estimating-the-association-between-women-8217-s-earning-8217-s-and-partner-violence-evidence-from-the-2008-2009-Tanzania-national-panel-survey>-холбоосноос үзнэ үү.

ДЭМБ (2005). Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн

талаарх олон Улсын судалгаа. Женев: ДЭМБ. <https://www.who.int/reproductivehealth/publications/violence/24159358X/en/-холбоосноос> үзнэ үү.

ДЭМБ (2013). Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн олон Улсын болон бүс нутгийн судалгаа: Дотно хамтрагчийн хүчирхийлэл болон хамтрагчийн бүс бэлгийн хүчирхийллийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл болон хувь хэмжээ: Женев: ДЭМБ. <https://www.who.int/reproductivehealth/publications/violence/9789241564625/en/-холбоосноос> үзнэ үү.

## ХАВСРАЛТ: СУДАЛГААНД АШИГЛАСАН ТААМАГЛАЛУУД

Зардлын тооцооны төрөл	Дэвшүүлсэн таамаглал
Хувиасаа гаргах эрүүл мэндийн зардал	<p>a. ДХХ-г мэдээлдэггүй, тусламж эрэлхийлэхгүй байх тохиолдлуудын хувьд ДХХ-ийн улмаас эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагатай болсон эсэх гэсэн асуулгад “Тийм” гэж хариулсан судалгаанд оролцогчийг эрүүл мэндийн үйлчилгээ авсан гэж үзсэн (байнга эрүүл мэндийн үйлчилгээ авдаг байж болно).</p> <p>b. 2017 оны ЖСХ/ЭЭХ-ийн судалгаанд тусламж авсан гэж мэдэгдсэн эмэгтэйчүүд 2017 онд ижил байгууллага буюу ГССҮТ-д хандан ижил хэмжээгээр ижил өртөгтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан гэж үзэж байна.</p>
Хувь хүн өөрөө гаргах нийгмийн үйлчилгээ авах зардал	<p>c. НЦҮТ болон бусад хамгаалах байранд байгаа хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хэдэн хувь нь хүүхэдтэй эсэх талаархи мэдээлэл байхгүй байгаа бөгөөд 2017 оны ЖСХ/ЭЭХ-ийн судалгаанд дурдсан “хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн 80,8 хувь нь хамгийн багадаа нэг хүүхэдтэй” гэсэн хувь хэмжээг ашиглав.</p> <p>d. Хувийн сургуульд хүүхэд нь суралцдаг хүүхдийн хувь хэмжээний талаархи мэдээлэл дутагдалтай байсан учраас хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн тал хувийнх нь хүүхэд нь хувийн сургуульд суралцдаг гэж тооцоолсон.</p>
Хувь хүн өөрөө гаргах гэр бүл салалтын зардал	Сүүлийн 12 сарын хугацаанд харилцааныхаа аль нэг үед ДХХ-ийн хүчирхийлэлд өртсөний улмаас гэр бүлээ цуцлуулсан эмэгтэйчүүдийн хувь хэмжээг гэр бүлээ цуцлуулсан хүчирхийлэлд өртсөн эмэгтэй болон амьдралынхаа аль нэг үед ямар нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн хувь хэмжээнд үндэслэн гаргасан (69,8 хувь).
Хөлсгүй хөдөлмөр буюу өрхийн үйлдвэрлэл болон асаргаа халамжийн ажлууд	ДХХ-ийн улмаас хийж гүйцэтгэдэг асран халамжлах ажлын зардлыг тогтоосон цөөн тооны улс орнуудын боломжит мэдээллийг үнэлэхэд Гана Улсыг манай улстай хамгийн ойролцоо гэж тооцсон болно.
алдагдсан орлого	<p>a. ЖСХ/ЭЭХ-ийн судалгаанд асуусан “Амьдралдаа хамтрагчийнхаа бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас ажиллаж хөдөлмөрлөж чадаагүй ажлын хоногууд” хэмээх (907a) асуулгыг ашиглан сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн ажил хөдөлмөр эрхэлдэг хохирогчийн сүүлийн 12 сарын хугацаанд бүртгэгдсэн ажилд яваагүй хоногуудыг тооцож гаргасан.</p> <p>b. Сүүлийн 12 сард дотно хамтрагчийнхаа махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн ажил хөдөлмөр эрхэлдэг хохирогч 365 хоног ажилдаа явж чадаагүй бол эдгээр өдрүүдийн тоог жилийн боломжит хамгийн их ажлын өдрийн нийт тоо болох 250 хоног хүртэл бууруулна.</p> <p>c. Хэрэв судалгаанд оролцогч энэхүү асуултанд “мэдэхгүй байна/ санахгүй байна” гэж хариулбал жишээ болгон ажилдаа явж чадаагүй ажлын хоногуудын дундаж тоог оруулна. Хэрэв хүчирхийлэлд өртсөн эмэгтэй асуултанд хариулахаас татгалзсан бол судалгаанд оруулж тооцохгүй.</p>
хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал	Мэдээлэл хүртээмжгүй байдлаас шалтгаалан (Хязгаарлалтын хэсгийг үзнэ үү) энэхүү судалгаанд өмнө нь Вьетнам Улсад хийсэн амьдралдаа ДХХ-д өртөж байсан эмэгтэйчүүд ДХХ-д өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн орлогоос ойролцоогоор 35 хувиар бага цалин авдаг гэсэн өртгийн судалгааны дүнг ашигласан болно (Дувври, Карни ба Нгүен, 2012). Салбарын дундаж цалинтай харьцуулан орлогын 15, 20, 25 хувийн өсөлтийн хэмжээг судалгааны тооцооллолд ашигласан.
Шаардлагатай хөрөнгө, эх үүсвэр	Нийт ГБХ-ээс гадна ДХХ-ийн улмаас үүссэн захиргааны зөрчлийн эзлэх хувийг тооцоолохдоо нийт ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргээс гадна ДХХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоогашигласан болно.